mminfo.mn
Шударга, Шуурхай, Өнцгөөр мэдээлэх

17 ДАХЬ ЖИЛДЭЭ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3.089.882... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.06.20. Даваа. №124 (4494) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг



**ОНЦЛОХ ХУУДАС**

ХУВЬЦАА ХУДАЛДАЖ АВАХ НЬ ЗӨВ, БУРУУ

МОНГОЛ АРДЫН НАМ
ХАНДИВЫН ДАНСАА НЭЭЛЭЭ

“ХААН БАНК”
5115028001 тоот данс

**Иргэн та хандив өргөхдөө**
Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу:
50.1.1 Иргэн гурван сая төгрөг хүртэл /регистерийн дугаар/
50.1.2 Хуулийн этгээд арван сая төгрөг хүртэл /регистерийн дугаар/

**Сонгуулийн тухай хуулийн 40.3-д:**
...“Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийн банкинд нээлгэсэн, сонгуулийн зардлын дансанд энэ хуульд заасан журмын дагуу төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулна” гэсэн, заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дансыг нээсэн тул намын гишүүд, дэмжигчид, дэмжигч байгууллага, иргэд та бүхнийг хандив өргөхийг хүсье.

Дугаарын 60 мөр

## Ажил, мэргэжилтэй болгоно гэхэд юунд дургүйцэв

Э.ТУУЛ

Энэ зууныг даяаршлын зуун хэмээн нэрийдэж, тэр ч утгаараа монгол залуус эх орноосоо гарч харь нутагт очиж амьдрах болсон. Бүр харийн хүнтэй гэр бүл болж, үр хүүхдийг нь төрүүлж айл гэр болон амьдардаг болоод байгаа. Тийм ч утгаараа харь оронд очиж “харлаж” амьдрах нь бараг л энгийн үзэгдэл болсон гэж хэлж болно. Дэлхийн аль ч оронд очсон монголчууд байдаг гэцгээдэг. Харин ихэнх нь хууль бусаар “харлаж” амьдардаг. Харласан монголчуудад ажил олддоггүй, олдсон ч хамгийн хүнд хүчир, хар ажил олдож, ээндээ бичиг баримтаа барьцаалан байж амьдрах аядаг нь үнэн. Хэрвээ баригдвал шууд л эх орон руу нь буцаана.

**Төгсгөл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ



# Эрээ цээргүй сурталчилгаа,
## ХУУЛЬ ЗӨРЧСӨН ҮЙЛДЭЛ ХЭРЭЭС ХЭТЭРЛЭЭ

Б.ТОГТОХ

УИХ-ын болон НИТХ-ын сонгуулийн сурталчилгаа эхлээд ес хонож байна. Шат шатанд ялалт байгуулахын төлөөх өрсөлдөөн эдгээр өдрүүдэд эрчимтэй өрнөж, гудамж талбайн нэр дэвшигчдийн инээсэн царай, элдэв сүржин уриа лоозонд дарагдчихаад байгаа юм.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ДЭЛХИЙ

## В.Путин Доналд Трампыг дэмжиж байна



Б.ДАВАА

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвшигч Доналд Трампыг дэмжиж буйгаа илэрхийлжээ. В.Путин Санкт Петербургийн олон улсын эдийн засгийн форумд оролцохдоо Доналд Трампыг ОХУ болон АНУ-ын харилцааг сайжруулах хүн гэж тодорхойлсон гэнэ. Тэрбээр “Ямар асуудал байгаа юм бэ. Бид дэмжинэ” гээд “АНУ-ын ард түмний санал бодлыг илэрхийлэх ямар ч Ерөнхийлөгч гарсан бид хамтран ажиллах болно. ОХУ-тай харилцаагаа сайжруулж, амар амгалан дэлхийг бүтээхийг төлөө ажиллах тийм хүн Ерөнхийлөгч болоосой гэж хүсч байна” гэсэн байна. Түүний энэ үгийг далдуур үл хэдлэх хөрөнгийн тэрбумтан Доналд Трампыг дэмжиж буйн илэрхийлэл хэмээн олон эх сурвалж дамжуулж байгаа юм. ОХУ-ын төрийн тэргүүний хувьд өмнө нь ч гэсэн Трампыг дэмжиж буйгаа ил шулуухан илэрхийлж байсан удаатай. Тодруулбал, тэрбээр жил бүр хийдэг 11 дэх удаагийн хэвлэлийн хурлынхаа үеэр “Доналд Трамп үнэхээр алдартай хүн. Түүнд үдирдах авьяас байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Түүнийг үнэлэх ёстой хүмүүс нь бид биш, АНУ-ын эрх баригчид. Тэр Ерөнхийлөгчийн сонгуулийн хөдөлгөгч хүч болж байна” хэмээн магтаж байсан юм. Түүнчлэн, Бүгд найрамдах намын нэр дэвшигч Трамп ч гэсэн ОХУ-ын удирдагчид найр тавьсан мэдэгдлийг хийж байсан билээ.




ӨӨР ӨНЦӨГ

## Газар наймаалсан мөнгө ОФФШОРТ БАЙРШСАН УУ

Э.ТУУЛ

Хотын дарга Э.Бат-Үүл, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Баттулга тэргүүтэй албаныхан өнгөрсөн долоо хоногт нийслэлийн өмнөх удирдлагуудтай холбоотой газрын хууль бус наймааны талаар баримттай мэдээлэл хийсэн билээ. Хурлын эхэнд Хотын дарга Э.Бат-Үүл нийслэлийн өмнөх удирдлагууд буюу М.Энхболд, Т.Билэгт, Ц.Батбаяр, Г.Мөнхбаяр нар Хотын даргаар ажиллах хугацаандаа 26.9 их наяд төгрөг буюу нийслэлийн 52 жилийн төсөвтэй дүйцэхүйц хэмжээний мөнгийг салхинд хийсгэж, захирамж нэрээр газар олголт хийсэн болохыг мэдэгдсэн. Энэхүү баримтыг Хотын дарга Э.Бат-Үүл ч гаргаад ирчихээгүй. Дэлхийн банкны 2013-2015 оны хооронд хийсэн судалгааны “Хотын өмнөх удирдлагуудын газар олголтоос алдсан орлогын тооцоолол” хэсэгт баримт, нотолгоотойгоо байна билээ. 2015 онд Дэлхийн банкнаас гаргасан “Монгол улс: Улаанбаатар хотын газрын харилцаа ба менежмент” гэсэн тайланд нэлээд ноцтой баримтууд бүртгэгдсэн нь энэ.

**Төгсгөл нь II нүүрт**




| | ХААН банк Авах | ХААН банк Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1945.00 | 1960.00 | ФУНТ | 2739.00 | 2822.00 | АМ.ДОЛЛАР | 1948.00 | 1962.00 | ФУНТ | 2766.00 | 2821.00 |
| ЕВРО | 2170.00 | 2222.00 | РУБЛЬ | 28.00 | 31.80 | ЕВРО | 2178.00 | 2225.00 | РУБЛЬ | 28.90 | 30.90 |
| ИЕН | 18.48 | 18.95 | ЮАНЬ | 294.30 | 297.80 | ИЕН | 18.53 | 18.98 | ЮАНЬ | 295.00 | 298.20 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Т.Лхагвасүрэнг ИНЕГ-т ажилд нь буцааж томилох шийдвэр гарчээ

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаад 2015 оны дөрөвдүгээр сарын 13-нд чөлөөлөгдсөн Т.Лхагвасүрэнг ажилд нь буцаан томилох эцсийн шийдвэрийг Улсын дээд шүүх гаргажээ. ЗГХЭГ-аас Төрийн албаны зөвлөлд сонгон шалгаруулалт захиалсны дагуу ИНЕГ-ын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтад Т.Лхагвасүрэн орж, оролцсон хүмүүсээс хамгийн өндөр оноо авсан аж. Улмаар ТАЗ-өөс түүнийг ИНЕГ-ын даргаар томилуулахаар нэрийг нь хүргүүлсэн ч даргын үүрэг гүйцэтгэгч гэсэн албан тушаалаас нь үндэслэлгүйгээр чөлөөлсөн байна. Засгийн газар "Бүтэц" орон тооны өөрчлөлтөөс болоод ажлаас чөлөөлсөн" хэмээн шүүхэд тайлбар гаргасан ч ИНЕГ-ын удирдлагын бүтцэд Т.Лхагвасүрэнгийн түр орлон ажиллаж байсан даргын ажил, албан тушаал, орон тоо хэвээр батлагджээ. Тйймээс Засгийн газрын 2015 оны 138 дугаар тогтоолыг шүүх хүчингүй болгож, түүний эрхэлж байсан ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажилд эгүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны олговор 25 сая гаруй төгрөгийг олгох, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт даатгалыг нь бичиж өгөхөөр болжээ.

mminfo.mn
Шударга, Шуурхай, Өнгөй мэдээлэл

МОНГОЛЫН МЭДЭЭ

17 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
88873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Тоймч:
Х.БАТСАЙХАН
88094039

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 210, 211 тоот**

**Харилцах утас, факс: 976-70113551**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ӨӨР ӨНЦӨГ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**






# Газар наймаалсан мөнгө ОФФШОРТ БАЙРШСАН УУ

Энэхүү тайланг Дэлхийн банкны Нийгэм, хот, хөдөө, сэргээн хөгжих асуудал эрхэлсэн газраас Улаанбаатар хотын захиргаатай хамтран 2013-2015 оны хооронд хийсэн судалгаанд тулгуурласан гэж байгаа. Тайланд тусгагдсан хүснэгтийг харахаар 26 их наяд 976 тэрбум 42 сая төгрөгийн газрыг хотын өмнөх удирдлагууд олгосон байна. Дэлхийн банкны судалгаагаар тогтоогдсон үнийн дүнг хамгийн багаар тооцсон бөгөөд 2012 он хүртэлх хугацаанд Хотын даргаар ажиллаж байсан хүмүүс шударга ажиллаж байсан бол хотын төсөвт дээрх хэмжээний мөнгө орох байжээ. М.Энхболд, Т.Билэгт, Ц.Батбаяр, Г.Мөнхбаяр гэсэн дөрвөн хүн хотын даргын алба хашч байхдаа эрх мэдлээ ашиглан олгосон газрын үнийг төсөвт төвлөрүүлсэн бол амласан ажлуудаа хийж дуусгаад, нүүр бардам байх боломж байсан уу гэвэл байсан. Гэвч тэд тэгээгүй. Одоо өнгөрсөн борооны хойноос цув нөмрөөд яах ч билээ дээ...

### Буруугаа хүлээх нь байтугай бухах шинжтэй болов уу даа

"Тухайн үед бидэнд ямар ч мөнгө байгаагүй, хэрвээ мөнгө байсан бол өнөөдрийн энэ ажлуудыг хийчих л байсан. Харин эд их мөнгөтэй болохоороо косметик мэс засал сайн хийж чадлаа" хэмээн гоншигоножбайсан хүмүүс эдүгээ буруугаа хүлээх нь байтугай бухаж, буруу зөрүү юм ярьж эхлэв бололтой. Өөрийг нь чадахгүй болохоороо үр хүүхэд, гэр бүл рүү нь дайрдаг зан тэднээс л эхлэлтэй. Нийслэлийн алга дарам газрыг ч үлдээлгүй зарсан хүмүүсийн үнэн дүр төрхийг хэн нэгэн биш, өөрсдөө л илчилсэн байдаг. Тэд газар зарсан гэх энэ баримтыг өөрсдөө хэвлэлээр гаргаж, цагдаад нэгийгээ өгснөөр тодорхой болсон байдаг гэнэ билээ. Хотын дарга асан Г.Мөнхбаяр, Т.Билэгт, газрын албаны дарга байсан Ц.Сандуй тэдний гар хөл Э.Ариунгэрэл, Д.Дашцэцэг зэрэг хүмүүсийн 240 удаагийн газрын наймааны хэргийн талаар Сү.Батболдын фракцийнхан цагдаад мэдээлснээр шалгаж эхэлсэн байгаа юм. Тэд сайндаа ч биш өөрийн фракцийн Д.Цогтбаатарыг Барилга, хот байгуулалтын сайдаар томилуулахын тулд өрсөлдөгч фракциас сайдад нэр дэвшсэн Ц.Сандуйгаа унагах гэж үүнийг хийсэн байдаг. Тэдний мэдээллийн дагуу Төрийн данс руу орох ёстой байсан 280 тэрбум төгрөг хаачсаныг тогтоохоор ажиллаж байгаа гэж цагдаагийнхан мэдээлсэн байна билээ. Хэрвээ дээрх газруудыг хууль ёсоор дуудлага худалдаагаар зарсан бол 26.9 их наядаас ч их мөнгө хотын төсөвт орох байв.

Дуудлага худалдаа хэзээ ч анхны үнэ дээрээ тогтдоггүй шүү дээ. Иймл байдлыг эдүгээгийн Хотын удирдлагууд засч, залруулж, ажлаа авсныхаа дараа 200 гаруй газрын зөвшөөрлийг хүчингүй болгожээ. Харин нэгэнт хууль бусаар олгогдсон барилга, байшин барьсан газрыг тэр чигт нь үлдээсэн гэсэн юм. Түүнчлэн барилга бариагүй, дамлан зарахаар нөөцөлсөн гэх газруудаас дуудлага худалдааны анхны үнийг төлбөрийн хугацаат график гарган нэхэмжилж байгаа аж. 2012-2016 оны хугацаанд нийт 68 тэрбум 493 сая төгрөгийг дуудлага худалдааны анхны үнэ гэж тооцож, төсөвт төвлөрүүлсэн бол 2016-2019 онд 10 тэрбум 506 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцоолжээ. Хүснэгтэд байгаа нь хууль хяналтынхны шалгаж тогтоогоод байгаа л газрын хэмжээ. Нийт газар олголтыг нэгбүрчлэн шалгах нь маш их цаг хугацаа, баримт мэдээлэл шаардаж байгаа аж. Хууль бусаар олгогдсон газарт нэгэнт баригдчихсан байшин барилгыг шинэ удирдлага өршөөн хэлтрүүлсэн гэдгийг энд цохон тэмдэглэмээр байна. Харин барилга байгууламж баригдаагүй, дамлан худалдах зорилгоор нөөцөлсөн газруудаас дуудлага худалдааны анхны үнийг төлбөрийн хугацаат график гарган нэхэмжлэх ажил дуусаагүй, үргэлжилсээр байгаа гэдгийг дуулгая.

### Ц.Сандуйг бодитой, баримттай тайлбар өгөхийг шаардав

АН-аас НИТХ-д нэр дэвшигч М.Цэвээн-Очир Сонгинохайрхан дүүргийн 4, 5, 26, 27 дугаар хорооны иргэдтэй уулзах үеэрээ нэгэн мэдэгдэл хийсэн юм. Тэрбээр "Нийслэлийн Ардчилсан намаас ИТХ-ын сонгуульд өрсөлдөж байгаа манай баг ялсан нөхцөлд Улаанбаатар хотыг хэнээр удирдуулахаа тодорхой болгочихсон. Манай багийн ахлагч Эрдэнийн Бат Үүл ирэх дөрвөн жилд Улаанбаатар хотыг үргэлжлүүлэн удирдахаар болсныг бүгд мэдэж байгаа. Гэтэл бидний өрсөлдөгч болох МАН-ын нийслэлийн хороо Бат-Үүл даргын адил Улаанбаатар хотыг хэнээр удирдуулах тухайгаа огт зарлахгүй, нуусан байдалтайгаар сонгуулийг дуусгах гэж байна. Олны ярьдгаар оффшор байдалд хотын даргад нэр дэвших хүнээ байлгаад байхаар ил гаргаач, зарлаач гэж би нэр дэвшигчийн, бас сонгогчийн хувиар шаардаж байна. Дэлхий нийтийн жишигт нийцүүлж ажиллабал Ардын нам хотыг удирдах багийн удирдагчаа бидэн шиг тодруулчихсан, олон түмэн сонгогчдод танилцуулж, хэлэлцүүлж, үнэлүүлж дүгнүүлчихсэн байх ёстой. Гэтэл одоогоор ямар ч нэр алга байна. Маш тодорхойгүй, нууцлагдмал байлгаж байна. Сураг сонсвол надтай ИТХ-ын нэг тойрогт өрсөлдөж байгаа Ардын намын нийслэлийн хорооны дарга Сандуй гэж хүн намынхаа дүрмийн дагуу хотын дарга болох санаа агуулж байгаа шиг байна. Тэгэхээр надад нэр дэвшигчийн хувиар, хотын жирийн иргэний хувиар түүнд тавих хэдэн асуулт байна аа. Хэд хоногийн өмнө Нийслэлийн Ардчилсан намын дарга Э.Бат-Үүл энэ сонгууль бол нийслэлийн газрыг хамгаалж үлдэхийн төлөөх "дайн" юм гэдгийг баримтад тулгуурлан мэдэгдсэн. Дэлхийн банкны судалгаагаар тогтоогдсон нэг том тоо байгаа нь 2012 он хүртэлх газар олголтоос хотын төсөвт орох ёстой байсан алдагдсан боломжийг 26.9 их наяд төгрөг хэмээн үнэлснийг ч дурьдаад авсан. Тэгэхээр хотын газрын будилаантай байнга нэр нь холбогдож явдаг Ц.Сандуй та зохих журмын дагуу буюу дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаар олгогдоогүй тэр их газар, тэр их мөнгө хаашаа орсныг өмнөх дөрвөн даргын үед газар олголтыг хариуцсан албан тушаалтан байсны хувьд тодорхой хариулж өгөөчээ. Дэлхийн банкны гаргасан судлагаанд дурьдагдсан тоо бол дуудлага худалдааны анхны үнээр баримжаалсан тооцоолол юм байна билээ.

Хэрвээ дуудлагаар оруулбал газар ямар үнэд орж болдгийг нйислэлчүүд өнгөрсөн дөрвөн жилд сайн мэдэж авсан. Улаанбаатар хэвлэх үйлдвэрийн газар дуудлагаар ямар үнэд хүрснийг бүгд мэдэж байгаа. 3000 орчим ам.метр газар 24 тэрбум төгрөгт хүрч зарагдсан. Би энд Ц.Сандуйгийн нэр бичигдсэн хэдхэн баримтыг авчирсан. Миний олсон энэ хэдэн баримтаар тооцоход л асар их хэмжээний орлого төсөвт ороогүй алдагдаж гэх хардлага үүсэхээр байгаа юм. Энэ баримтуудтай та бүхэн танилцаж болно.

Дараагийн нэг чухал асуулт нь Ц.Сандуйн төрсөн дүү Сэргэлэн гэх залуугийн нэр Олон улсын эрэн сурвалжлах нийгэмлэгээс оффшорт данс эзэмшдэг монголчуудын нэг гэж зарлагдсан. Сэргэлэн дөрвөн данс эзэмшдэг нь тодорхой болсон. Гэтэл Ц.Сандуй одоог хүртэл ямар нэг тайлбар хийсэнгүй. Тэгэхээр би эхэнд дурьдсан тоо болон Сэргэлэнгийн оффшорт байгаа дөрвөн данснуудын хооронд холбоо байгаа юм биш биз гэж хардаж байна. Ц.Сандуй та, 26.9 их наяд төгрөгөөр үнэлэгдэх их газрыг олголцсон албан тушаалтны хувьд хувьдаа ямар нэг мөнгө авч, улмаар дүүгийнхээ нэр дээрх оффшор дансанд хийчихсэн юм биш биз дээ. Иргэдтэй уулзалт хийх бүр 40, 50 хувь нь надаас үүнийг л асууж байна. Би иргэдийн захиасаар танаас энэ талаар тайлбар авмаар байна. Танаас бидний эргэлзээг тайлж, тайлбар хийхийг шаардаж байна. Таныг 2016 оны зургадугаар сарын 20-ны өдрийн 14:00 цаг гэхэд нийслэлийн иргэд, сонгогчдод хууль журам зөрчсөн газар олголтын мөнгө хаашаа ордог байсныг, мөн дүүгийнхээ нэр дээр оффшорт байгаа дөрвөн данс руу ямар орлогоо хийдэг байсан эсэх талаараа бодитой, баримттай тайлбар өгөхийг шаардаж байна.

Дурьдсан хугацаанд хариу өгөхгүй бол би тэмцлийн дараагийн шатанд шилжиж, зохих хууль хяналтын байгууллагуудад таныг шалгуулах хүсэлтээ гаргах болно. Та НИТХ-д нэр дэвшигчийн хувьд миний асуултад хариулах үүрэгтэй. Танаас хатуу шаардаж байна" гэх мэдэгдлийг хийсэн. Үнэхээр ч түүний нэгэн адил хардах эрх түмэнд бий. Тэгээд ч google хайлтад Ц.Сандуйн нэрийг бичихэд л түмэн зүйлийн мэдээлэл толгой эргүүлэх юм билээ. Тэнд түүнийг "нийслэлээс төрсөн тэрбумтан" гэж хүртэл цоллосон байна билээ. Яг л төрөөс төрсөн тэрбумтан гэдэг шиг, тийм л аргаар хөлжсөн нэгэн гэдэг нь илэрхий. Харин тэр сонгогчдын эргэлзээг тайлж, өнөөдөр 14:00 цаг гэхэд нийслэлийн иргэд, сонгогчдод хууль журам зөрчсөн газар олголтын мөнгө хаашаа ордог байсныг, мөн дүүгийнхээ нэр дээр оффшорт байгаа дөрвөн данс руу ямар орлогоо хийдэг байсан эсэх талаараа бодитой, баримттай тайлбар өгөх буй заа.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## "Улаанбаатарын яриа хэлэлцээ" бага хуралд оролцож буй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав

Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх "Улаанбаатарын яриа хэлэлцээ" Олон улсын III Бага хуралд оролцож байгаа гадаадын төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. "Зүүн Хойд Азийн асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ" санаачилгын хүрээнд зохион байгуулдаг тус Бага хуралд олон улсын нэр хүндтэй эрдэмтэн судлаачид, салбарын мэргэжилтнүүд оролцож бүс нутгийн хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцэж санал солилцдог уламжлалтай. Гурав дахь удаагийн хурлаар ЗХА-ийн аюулгүй байдлын өнөөгийн байдал, учирч буй сорилт бэрхшээл, бүс нутагт харилцан ойлголцол, итгэлцэл бий болгох арга зам, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих асуудлаар эрдэмтэн, судлаачдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэхийн зэрэгцээ бүс нутгийн хүрээлэн буй орчныг хамгаалах, гамшгийн менежментийн талаар талууд анх удаа туршлага солилцлоо.

Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн Зүүн хойд Азийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд Монгол Улс хувь нэмрээ оруулан ажиллахыг зорьж байгааг




тэмдэглээд Монгол Улсын гадаад бодлогын асуудлаар төлөөлөгчдийн сонирхсон асуултад дэлгэрэнгүй хариулт өгөв. Энэхүү хурал нь зургадугаар сарын 16-нд Улаанбаатар хотноо нээгдсэн. Хурлыг Гадаад хэргийн яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэн хамтран зохион байгууллаа. Хоёр өдөр үргэлжилсэн Бага хуралд БНХАУ, ОХУ, БНАСАУ, БНСУ, Япон, АНУ, Герман, Энэтхэг, Их Британи, Австрали, Францын эрдэмтэн судлаачид, мөн НҮБ, Олон Улсын Улаан Загалмайн Хороо, Фридрих Эбертийн Сан зэрэг олон улсын байгууллагын төлөөлөгчид, мөн дотоодын төр, хувийн хэвшлийн төлөөлөл нийт 150 гаруй төлөөлөгч оролцов.

Бага хуралд БНАСАУ-ын ГХЯ-ны Америк судлалын хүрээлэнгийн хэлтсийн дарга Чой Кан Ил, БНСУ-ын Сэжон хүрээлэнгийн дэд захирал Ли Сан Хен, АНУ-ын Жрн Хопкинсын их сургуулийн ахлах судлаач Жени Таун, БНХАУ-ын Олон улс харилцааны хүрээлэнгийн орлогч захирал Сун Ру, ОХУ-ын ШУА-ийн ахлах судлаач Елена Боекова зэрэг эрдэмтэн судлаачид бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн өнөөгийн байдал, чиг хандлага, байгаль орчны салбарын хамтын ажиллагааны талаар илтгэл тавилаа. "Улаанбаатарын яриа хэлэлцээ" санаачилгын хүрээнд өмнө нь ЗХА–ийн орнуудын эмэгтэй парламентчдын чуулга уулзалт, хотын дарга нарын форум, эрчим хүчний хэлхээ холбоо семинар, Залуучуудын чуулга уулзалт тус тус зохион байгуулагдсан юм.

## Ганцаараа амьдардаг иргэний хаяг дээр хүмүүс нэмэгдэх болжээ

Засгийн газрын харьяа "11-11" төвд өнгөрч буй долоо хоногт иргэдээс олон гомдол иржээ. Хамгийн анхаарал татах гомдлыг №1606175265 дугаартай зочин ирүүлсэн байна. Тэрбээр "Сонгинохайрхан дүүргийн 22-р хороо Баянголын амны 11-1 тоотод ганцаараа амьдардаг иргэний хаяг дээр 4-5 хүн нэмэгдсэн байна. Тухайн асуудлыг шалгаж өгнө үү" гэжээ. Сонгуулийн үеэр хаяг дээр нь амьдардаггүй хүмүүсийг бичиж, санал өгүүлдэг гэсэн яриа бий. Тиймээс эл асуудлыг холбогдох газрууд нь шалгаж нягтлах. Мөн иргэд бүртгэлээ хянах шаардлага тулгарч байгааг ч эндээс харж болохоор байгаа юм. Мөн "Иргэний улсын бүртгэлийн гадаад паспорт олгодог хэсэгт битүү дараалал ихтэй агааржуулалт байхгүй хүндрэлтэй байна. Ажиллах хүчээ нэмж өгнө үү" гэсэн бол өөр нэг иргэн "ЭМД-аар хөнгөлөлттэй эм авах гэсэн хөнгөлөлттэй эм дууссан гэж байна. Арга хэмжээ авч хэвийн олгож өгнө үү" гэжээ. Төрийн байгууллагуудын лавлах утаснууд төлбөртэй байгаа асуудлыг зогсоож, зохицуулж өгөх шаардлагатайг ч иргэд хэлж Авто тээврийн газар, Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний газрын утсыг төлбөргүй болгохыг хүссэн байна.

АСЕМ-11

## Дээд хэмжээний уулзалтын үеэр "Нүүдэлчдийн наадам" хийнэ

Ази, Европын Дээд түвшний XI уулзалт 2016 оны долдугаар сард Улаанбаатар хотод болно. Энэ уулзалтад 15 орны Ерөнхийлөгч, 21 орны Ерөнхий сайд болон Гадаад хэргийн сайд нар, олон улсын байгууллагын удирдлага, хэвлэл мэдээллийнхэн зэрэг нийт 5000 гаруй зочид, төлөөлөгч оролцохоор төлөвлөж байгаа юм. Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн ахалж буй Дээд хэмжээний энэ уулзалтыг зохион байгуулах ажлыг удирдан зохион байгуулах, чиг үүргээр хангах Үндэсний зөвлөлийн 30 дугаар хуралдаан өнөөдөр боллоо. Үндэсний соёл, амралтын хүрээлэн, Шангри Ла зочид буудлуудын хооронд "Гэр хотхон" байгуулахаар төлөвлөсөн. Хотхоны орчмын зүлэгжүүлэлт, тохижилт болоод Нүүдэлчдийн наадам хийх "Чингисийн хүрээ" цогцолборын бэлтгэлд ажилд анхаарч ажиллахыг Ерөнхий сайд үүрэг болголоо.

## ҮЗЭЛ БОДОЛ

# Эрээ цээргүй сурталчилгаа,

## ХУУЛЬ ЗӨРЧСӨН ҮЙЛДЭЛ ХЭРЭЭС ХЭТЭРЛЭЭ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Цахим хуудсаар дүүрэн нэр дэвшигчийн сурталчилгаанаас залхсан пост хөвөрч, морьтой, машинтай, явганаар сурталчилгаагаа хийсэн нэр дэвшигчдийн элдэв "чамин" зураг эмх замбараагаа алджээ. Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулснаар нэр дэвшигчдийн сурталчилгааны хугацааг 18 хоног болгосон. Мөн сонин хэвлэл, телевизээр хийх сурталчилгааны цагийг багасгаснаас үүдэж ийн эрээ цээргүй сурталчилгаа хэрээс хэтрээд буй юм. Нийслэлийн гэр хороололд тэр тусмаа нэр дэвшигчдийн самбар, уриа лоозон бүр эмх замбараагаа алдаад байна. Нөгөө талаар өрсөлдөөн өнөө жил шударга байж чадахгүйг илтгэх олон янзын зохион байгуулалттай үйлдэл гарч байгаа. Тэр тусмаа өрсөлдөгчөө унагаж, өөрийгөө мундаг болгож харагдуулах гэсэн арга ядсан сурталчилгаа, зохион байгуулалттай үйл ажиллагаа ойрын өдрүүдэд эрчимжиж байна. Сурталчилгаа эхэлсэн ес хоногт бид тойргийн өрсөлдөөний төлөө эрчүүд хэрхэн улайрч, эмэгтэй нэр дэвшигчийг түлхэн унагах гэж оролдсоныг харлаа. Зохион байгуулалттайгаар хурал тасалдуулах ажлыг нөгөө намынхаа захиалгаар хийж буй үйлдэл ч олон гарав. Цаашлаад өрсөлдөгчийнхөө уриа лоозонг урж тасдах, санал өгүүлэхийн тулд нийслэлээс хөдөөг чиглэсэн шилжилт хөдөлгөөн их хэмжээгээр хийх, төрийн албан хаагчдыг төлбөргүй амралтад явуулах зэрэг хууль бус үйлдэл улам бүр газар авч байна. Үүнийг сэтгүүлч би санаанаасаа зохиож бичсэнгүй. Сошиал ертөнцөөр тархсан бичлэг, баримттай зураг хөрөг, мөн иргэдийн ирүүлсэн гомдол санал зэргээс үндэслэж бичсэн нь энэ.

### Шударгаар өрсөлдөөч

Ингэж хэлмээр олон үйл явдал гарлаа. Өнөө жилийн сонгуулийн хууль тун ч хатуу байгаа. Тиймдээ ч хотын төвд нэр дэвшигчид сурталчилгааны том самбар түрээсэлж, уриа лоозонгоо өлгөх эрхгүй болсон юм. Тэр ч утгаараа гэр хороололд явган хүний зам талбайг ашиглаж нэр дэвшигчид уриа лоозонгоо тавьж, мөн гудамжны гэрлийн шонд жижиг хэмжээтэй самбар байршуулсан билээ. Харин энэ нь өрсөлдөгчийн ухуулагч нарт бэлэн өгөөш болсон нь илт. Сурталчилгаа албан ёсоор эхэлсний маргаашаас эхлээд л нэр дэвшигчдийн сурталчилгааны самбарыг урж тасдсан хэрэг гарав. Мэдээж улс төрийн зорилго агуулсан нь тодорхой. Зарим нэр дэвшигчид уг асуудлыг шалгуулахад насанд хүрээгүй хүүхдүүдээр хийлгэсэн тохиолдол ч илэрч байлаа.

Энэ мэтээр өрсөлдөгчөө илт давуу ялж чадахгүй учраас арга ядсан үйлдэл хийж эхэлжээ, тэд. Сонгуулийн тухай хуульд өрсөлдөгчийнхөө сурталчилгааны материалыг гэмтээсэн, урсан тохиолдолд тодорхой хэмжээний мөнгөн торгууль ногдуулах заалттай. Тодруулбал, Сонгуулийн тухай хуулийн 78.11-д Энэ хуулийн 78.10-т (Сонгуулийн сурталчилгааны самбарыг хууль бусаар устгах, гэмтээх, бохирдуулахыг хориглоно) заасныг зөрчсөн аливаа этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 6-8 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заажээ. Тиймээс иргэд сурталчилгааны самбарыг урж буй хүмүүсийн талаархи мэдээлэл холбогдох газарт өгч болох юм байна.

### Эмэгтэйчүүдээс "айгаад" байна уу

УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг өнгөрөгч долоо хоногт олны анхааралд байв. Түүний нэр хүндийг санаатайгаар унагах гэсэн шударга бус үйлдлийн эзэд нь түүний өрсөлдөгчид байж таарлаа. Тодруулбал, 72 дугаар тойрогт нэр дэвшигч Т.Алтаншагай, мөн тус дүүрэгт нэр дэвшигч Х.Бат-Ялалт нар хамтран мэдэгдэл хийж, Л.Эрдэнэчимэг гишүүний Төрийн ордны өрөөнд архи ууж, тамхи татаж буй бичлэгийг олон нийтэд ил болголоо. Гэвч энэ нь Л.Эрдэнэчимэгийн нэр хүндийг унагах гэхээс илүүтэй өрсөлдөгчөө увайгүй аргаар дарах гэсэн Т.Алтаншагай, Х.Бат-Ялалт нарын нэр хүндэд сөргөөр нөлөөлж эхэлсэн гэхэд болно. Төрийн ордонд баталсан хуулиа үл дагасан эмэгтэйг буруутгах нэгэн байсан ч гишүүний зөөлөн суудлын төлөө улайрсан үйлдэл гаргасан эрчүүдийг нийгэм тэр чигээрээ буруутгав. Өнөөх хоёр сүүлдээ энэхүү бичлэгийг Л.Эрдэнэчимэг гишүүнтэй нэг тойрогт өрсөлдөж буй МАН-ын нэр дэвшигч Н.Учралаас авсан мэтээр өөрсдөөсөө холдуулж, Н.Учралд Г.Уянга гишүүн 200 сая төгрөгөөр зарсан мэтээр ойлголт өгч эхэлсэн. Энэ асуудлын ээдрээ өнөөдрийг хүртэл тайлагдаагүй байгаа юм.

Утга учиргүй хар пиартаа өөрсдөө унаж орхисон эрчүүдийн энэ үйлдэл хамгийн увайгүй сөрөг сурталчилгаа байв. Тэгвэл Л.Эрдэнэчимэг гишүүний эсрэг чиглэсэн сөрөг пиарын үйлдэл энэ хүрээд дуусаагүй юм. Тодруулбал, Л.Эрдэнэчимэг гишүүний сурталчилгааны фэйж хуудас хакердуулж, олон мянган сөрөг сэтгэгдэл нэгэн зэрэг оржээ. Мөн 60 гаруй мянган дэмжигч гишүүд рүү нь гишүүний фэйж хуудаснаас худлаа мэдээлэл явуулсан байх магадлалтайг сонгуулийн штабаас нь мэдэгдэж, хэвлэл мэдээллээр дамжуулан мэдэгдэл гаргажээ. Мөн Баянзүрх дүүрэгт нэр дэвшигч П.Анужингийн өрсөлдөгчид түүний эсрэг увайгүй гүжир бичлэг цацсан ч, энэ нь баталгаатай байгаагүйгээс хэд хэдэн сайтууд үйл ажиллагаа явуулах эрхээ зургаан сараар хаалгалаа.

### "Царцааны нүүдэл" аймгуудыг чиглэв

Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн энэ өдрүүдэд айл айлын хаалгыг сурталчилгааны ухуулагч нар нүдэж буй. Тэд нэр дэвшигчдийнхээ сурталчилгааны материалыг тараагаад өнгөрөх нэг хэрэг. Гэтэл таны утасны дугаар, регистрийн дугаарыг тэмдэглэн авч байгаа нь өөрөө хууль зөрчсөн үйлдэл. Иргэн та сурталчилгааны мэдээлэл авах эрхтэй ч хэний ч мэдэхгүй нэг хүнд утасны дугаар, регисрийн дугаараа өгч хэрхэвч болохгүй. Регистрийн дугаарыг тань тэмдэглэж авна гэдэг эргээд таныг мөнгө өгнө гэж шантаажлах, хэн нэгнийг дэмж хэмээн дарамтлах магадлалыг нэмэгдүүлнэ. Мөн таны санал хууль бусаар өөр хэн нэгэнд очих магадлал ч нэмэгдэх учиртай. Хорооны ахлагч нар иргэдийн утасны дугаар, гэрийн хаягийг нууцлах ёстой ч эсрэгээрээ сонгуулийн штабуудад өгдөг асуудал улам бүр газар авч байгааг өөрийн биеэр мэдэрсэн учраас ийн сануулсан хэрэг. Нөгөө талаар хэний ч танихгүй гэр бүлийн гишүүн танайд нэмэгдэх зөрчил ихэсч буйг дуулгая. Учир нь айлын хаяг дээр өөрт нь санал өгөх өөр дүүргийн сонгогчдоо нэмж бүртгэх, шилжилт хөдөлгөөн нэрийдлээр нэг аймгаас нөгөө рүү шилжих асуудал ойрын өдрүүдэд ихэсчээ.

Тиймээс хороогоороо орж гэрийн хаяг дээрээ хэн хэн байгааг шалгахад гэмгүй болов уу. Засгийн газрын "11 11" төвд ганц бие оршин суугчийн хаягт сонгуулийн энэ өдрүүдэд маш олон хүн нэмэгдсэн тохиолдол гарсныг тухайн хаягийн оршин суугч утасдаж мэдэгджээ. Мөн Хөвсгөл, Баянхонгор аймаг руу MCS компанийн олон мянган ажилчид амралтаараа явна. Сонгуулийн үеэр эдгээр аймгуудад байх шаардлагатай хэмээн шилжилт хөдөлгөөн хийлгэсэн гэх мэдээлэл цахим хуудсаар тарж эхэлжээ. МАХН-ын зүгээс ч үүнийг баримтжуулсан хэмээгээд Тагнуулын байгууллагад шалгуулахаар болсноо дуулгасан юм. Төрийн албан хаагчдыг амралтад явуулах, өөрийнхөө компанийн ажилчдыг мөн л амралтын шугамаар сонгуулийн үеэр амраах зэрэг асуудал ч Сэлэнгэ зэрэг аймгуудад гарч эхэлсэн гэх. Үүнийг сонгуулийн пиарын хэллэгээр "царцааны нүүдэл" хэмээдэг бөгөөд 1990 оноос хойш сонгогчийн саналыг хууль бусаар авах хамгийн шалгарсан арга байжээ. Хөвсгөл аймагт мөн наймдугаар хороо руу их хэмжээний иргэн шилжиж, бүр нэг байранд 10-уулаа шахалдан амьдарч байгааг нэгэн иргэн сэтгэгдэлдээ дурьджээ.

### Архины мөнгөөр хурал үймүүлэгчид

Өмнө хэлсэнчлэн өнөө жилийн сонгуулийн хууль нэр дэвшигчдэд тун ч хатуу байгаа. Тэр тусмаа шинээр УИХ болон НИТХ-д өрсөлдөж буй хүмүүсийн хувьд 18 хоногт багтаан өөрийгөө таниулна гэдэг хэцүү. Юу ч хийгээгүй тэдэнд бусдаар өөрийгөө магтуулж яриулахаас өөрөөр ард түмэнд танигдах хэцүү. Тэгвэл эдгээр шинэковууд өрсөлдөгчөө унагахын тулд арга ядсан үйлдэл хийж эхэлжээ. УИХ-ын дарга өнгөрөгч долоо хоногт Увс аймагт ажиллах үеэр түүний хурлыг санаатайгаар тасалдуулах үйлдэл гарав. Тодруулбал, Ю.Цэдэнбал агсаны ойг тэмдэглэн өнгөрүүлэх зарлигийг гардуулах үеэр нэгэн иргэн зохион байгуулалттай эсэргүүцэл илэрхийлж, түүний дохиогоор хурлын урдуур сууж байсан хэсэг залуус индэр рүү үсрэн гарч үймүүлж эхэлсэн гэнэ. Энэ үйлдэл нь аль ч талаас харсан хууль зөрчсөн үйлдэл. Муу ч сайн ч төрийн гурван өндөрлөгөө монгол түмэн хүндэтгэдэг. Тиймдээ сонгуулийн сурталчилгаагаа ийм увайгүй аргаар хийж буй сөрөг намынханд Увсын ард түмэн дургүйцэж байжээ. Харин МАН-ыг дэмжигчид Увсын ард түмэн зөв үйлдэл хийлээ. З.Энхболд дарга Ю.Цэдэнбал даргыг цагаатгах тогтоолыг эсэргүүцсэн хүн. Тиймдээ ч ийм хариу авах нь зөв хэмээн өөгшүүлж байв. Тэгвэл Хан Хэнтий нутгаас УИХ-д нэр дэвшч буй Б.Гарамгайбаатар гишүүний сонгуулийн хурлыг мөн л нэгэн согтуу нөхөр үймүүлэх оролдлого хийжээ. Тэрбээр, олон улсын ажиглагч эмэгтэйг илж таалан олны доог тохуу болж, хуралд дэмжихээр ирсэн хүмүүсийг зодож танхайрсан гэх. Ёсзүйгүй авирласан энэ үйлдлээ согтуу нөхөр өрсөлдөгчийн ухуулагч надад архины мөнгө өгсөн. Тэгээд хурал үймүүл гэж хэлсэн хэмээн мэдүүлсэн гэх. Энэ мэтээр архины мөнгөөр хурал үймүүлдэг зохион байгуулалттай үйл ажиллагаа ч эдгээр өдрүүдэд эрчимжиж эхлэв бололтой. Аль ч тохиолдолд бид төрийн хуулиа хүндлэх ёстой.

Тэр тусмаа сонгууль мөнхөд үргэлжлэхгүй. Цаг хугацаатай зүйл болоод л дуусна. Тэр цагт эргэж уулзах нүүртэй үлдэнэ гэдэг хамгийн сайхан. Нэр дэвшигчид сурталчилгаа эхлэхийн өмнөхөн шударгаар өрсөлдөнө хэмээн мэдэгдэж байв. Гэвч есхөн хоногийн хугацаанд тэд амласнаа мартчихаад алийгаа алдаж байна. Цаашид төрийн эрхийг хууль бусаар авах гэсэн ямар үйл явдал өрнөхийг тааж хэлэх аргагүй. Дахин сануулахад, сонгууль мөнхөд үргэлжлэхгүй. Тиймээс төрийн эрх барихын төлөө шударгаар өрсөлдөөч хэмээн уриалъя.

...Хөвсгөл, Баянхонгор аймаг руу MCS компанийн олон мянган ажилчид амралтаараа явна. Сонгуулийн үеэр эдгээр аймгуудад байх шаардлагатай хэмээн шилжилт хөдөлгөөн хийлгэсэн гэх мэдээлэл цахим хуудсаар тарж эхэлжээ. МАХН-ын зүгээс ч үүнийг баримтжуулсан хэмээгээд Тагнуулын байгууллагад шалгуулахаар болсноо дуулгасан юм...

HERBALIFE
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ШИМ ТЭЖЭЭЛ

**УРИЛГА**

**ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ**

**Хэн:** Herbalife компанийн Хүнс тэжээлийн боловсрол, хөгжлийн асуудал эрхэлсэн дэд ерөнхийлөгч, доктор, нийгмийн эрүүл мэндийн ухааны магистр Луижи Граттон
Herbalife компанийн Монгол дахь суурин төлөөлөгч Ганболдын Дэнзэн

**Юу:** Herbalife компани нь АНУ-ын хүнс тэжээлийн шинжлэх ухааны тэргүүлэх зэргийн мэргэжилтэн Доктор Луижи Граттоны хэвлэлийн бага хуралд сэтгүүлчдийг урьж байна. Доктор Граттон хүнс тэжээл, хөгшрөлтийн эсрэг анагаах ухаан, спортын хүнс тэжээл болон анагаах ухааны бусад сэдвийг хөндөж ярина. Ганболдын Дэнзэн Herbalife компанийн Монгол улс дахь үйл ажиллагааны талаар ярина.

Энэ үеэр тусдаа ярилцлага хийх хүсэлт хүлээж авахгүй. Доорх хаягаар Б. Жаргалтай холбогдож, нэмэлт мэдээлэл авна уу.

**Хаана:** Бэствэстэрн Туушин зочид буудал, Сүлд танхим

**Хэзээ:** 2016 оны 6 сарын 20, 9:40 – 11

**Хуваарь:** 09:45 Цай/кофе/коктейль болон зуушаар үйлчилнэ.
10 Хэвлэлийн бага хурал
11 Цай/кофе/коктейль болон зуушаар үйлчилнэ.

**Холбоо барих хүн:** Менежер, зар сурталчилгааны материал боловсруулагч
Бямбасүрэнгийн Жаргал
**99072502** jargal.b@breakthroughpr.mn

Дугаарын **60** мөр

## Ажил, мэргэжилтэй болгоно гэхэд юунд дургүйцэв

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ бол "харьд харлагсад"-ын зовлон. Саяхан хэсэг найз нар маань, Монголын залууст сэтгэл хангалуун амьдрахын тулд хоёр зам л үлдэж хэмээн ярив. Эхнийх нь аль нэгэн улс төрийн намд элсч, хэн нэгний гар хөл болох. Нөгөөх нь гадаадад гарч, хүнд хүчир ажил хийх хэмээн ярьсан юм. Тухайн үед нэг их тоогоогүй өнгөрүүлсэн энэхүү яриаг хүлээн зөвшөөрөхөөс ч өөр аргагүй үнэн болж байх шиг. Яг үнэндээ одоо сонгуулийн сурталчилгаа, хар цагаан пиарын дунд монголчууд өдөр хоногийг өнгөрүүлж байна. Энд тэндгүй л хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнаж байх зуур ажил хийгээгүй нөхдүүд амаа цангатал хэн нэгнийг муулж, шүүмжилж байна.

Үүний тод жишээ бол Японд ажиллах хүч гаргаж, иргэдийнхээ амьдралыг дээшлүүлнэ хэмээн зорьсон хүмүүсийн ажлыг харлуулж эхэлсэн явдал. Учир юу хэмээвээс, УИХ-ын дарга Япон улсад айлчлаад ирэхдээ Эдийн засгийн түншлэлийн гэрээ байгуулсан. Энэ гэрээг хэрэгжүүлэхэд хөрөнгийн урсгалаас гадна хүн хүч, мэргэжилтний урсгалыг зайлшгүй бий болгох шаардлагатай. Энэ ч үүднээс Монгол Улсаас Япон улсад мэргэжлийн ур чадвартай залуучуудыг бэлтгэх зорилгоор хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан юм.

Харин Монгол Улсын Засгийн газар хоорондхөдөлмөрийн салбарт хамтран ажиллах санамж бичигт Хөдөлмөрийн сайд гарын үсэг зурсан. Энэ ямар учиртай вэ гэвэл, Япон улсаас технологи импортлох, ноу хау-д суралцах, залуучуудыг дорнын соёл, технологийн дэвшлээс суралцуулах зорилготой хэмээн сайд тайлбарлаж байсан. Хамгийн гол тодорхой тохирсон нэг зүйл нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хэдий хэмжээний мэргэжлийн ур чадвартай залуус хэрэгтэй байна, тэр хэмжээгээр Япон улсад дадлагажуулна гэсэн байгаа юм. Тэгэхээр манай зүгээс залуучуудаа МСҮТ-өөр дамжуулан хэлний бэлтгэлд хамруулж, Япон улсад дадлагажуулна гэсэн үг. Түүнээс гадна Япон улс 2020 онд нийслэл Токиодоо зуны олимпийн 32 дугаар наадмыг зохион байгуулах эрх авсан. Олимпийн бэлтгэл хангах их бүтээн байгуулалт өрнөхтэй холбоотойгоор тус улс барилгын салбартаа шаардлагатай ажиллах хүчнийг гаднаас авах тухай яригдаж байгаа энэ үед 10 мянган залууг ажиллах хүчнээр Япон руу явуулж, мэргэшүүлнэ гэдэг сайхан ажил. 18-39 насны залуус Японы технологийн салбарын зах зээл дээр хөдөлмөр эрхлэн эргээд эх орондоо мэргэжилтэй боловсон хүчин болон ирж хамтдаа хөгжих сайхан боломж бүрдэж байна гэсэн үг.

Яг үнэндээ тэд залуусыг хар ажилд явуулъя, хараар амьдруулъя гэсэнгүй. Япон шиг өндөр хөгжилтэй оронд очоод, ажил сураад ирэхэд юу нь болохгүй гэж. 10 мянган айл хүүгээ, охиноо өндөр хөгжилтэй улс руу явуулж, мэргэжилтэй боловсон хүчин болгоод авна. Эх орондоо ирээд ажил хөдөлмөр эрхлээд эхэлбэл тэр хэмжээгээрээ дипломтой ажилгүйчүүдийн тоо багасч, олон айлын амьдрал ахуй сайжирна. Хүн ажилтай болгож өгье гэхэд дургүйцэх хүн тэр бүр гарахгүй л болов уу. Халамж аваад сурчихсан, хүнээр тэжээлгээд сууж байх дуртай хүн цөөхөн байгаа гэдэгт итгэж байна. Ер нь ч тэгээд өндөр хөгжилтэй өөр орнуудтай ч гэсэн энэ мэт гэрээг хийж, ажилгүй залуусаа ажилтай, орлоготой болгох асуудлыг хоёр гараа өргөөд дэмжих хэрэгтэй. Улстөржилт, сонгуулийн хар пиар энэ ажилд бүү саад болоосой.

## ДЭЛХИЙ

# "Лалын улс" ГЭЙ КЛУБЫГ онилж, БРИТАНИЙН УЛСТӨРЧ АМИА АЛДСАН долоо хоног



Б.ДАВААХҮҮ

*Өнгөрөгч долоо хоногт дэлхий дахинаа болсон онцлох үйл явдлыг тоймлон хүргэж байна.*

### "Лалын улс" гэй клубт халдлага үйлдэв

"Лалын улс" бүлэглэлийн нэгэн гишүүн гэй клубт халдлага үйлдсэн харамсалтай мэдээтэйгээр өнгөрөгч долоо хоног эхэлсэн билээ. Тодруулбал, АНУ-ын Флорида мужийн Орландо дахь бэлгийн цөөнхийнхний үйлчлүүлдэг шөнийн клуб руу буутай этгээд халдаж, 49 хүний аминд хүрч, 53 хүнийг шархдуулсан аймшигт хэрэг даваа гарагийн үүрээр гарсан юм. Гэй клуб руу халдлага үйлдэгч этгээд хэргийн газар дээрээ цагдаагийн алба хаагчид буудуулж нас барсан байдаг. Түүнийг "Лалын улс" бүлэглэлийн дайчин байсныг АНУ-ын Холбооны мөрдөх товчоо мэдээлсэн. Учир нь тэрээр халдлага үйлдэхээсээ өмнө 911 рүү залгаж, тус хэт даврагч бүлэглэлд үнэнч байхаа тангарагласан хэмээсэн аж. Мөн өөрийн фэйсбүүк хуудастаа "Ойрын өдрүүдэд Лалын улс бүлэглэл АНУ-д халдлага үйлдэхийг харах болно" гэж бичсэн байжээ. Энэ удаагийн халдлагыг үйлдсэн 29 настай Омар Матин гэгчийг Холбооны мөрдөх товчоо 2014 оноос хойш тагнаж байжээ. Тухайн үед Сирид амиа золиослосон Флорида мужийн иргэнтэй холбоотой байж магадгүй хэмээн сэжиглэж байсан аж. Тэгвэл дээрх хэрэг гарсны дараа Лалын улс бүлэглэл уг халдлагыг үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн төдийгүй Омар Матин гэгчийг тус бүлэглэлийн гишүүн байсан гэдгийг тодотгосон байгаа юм. Нөгөө талаар хэрэгтний аав хүүгээс террорист бүлэглэлийн гишүүн биш хэмээгээд бэлгийн цөөнхийнхнийг үзэн яддаг байсныг гэрчилсэн байдаг. АНУ-ын түүхэн дэх хамгийн олон хүний амь үрэгдсэн зэвсэгт халдлагын дараа дэлхийн улс гүрний удирдагчид терроризмыг эсэргүүцэж буйгаа илэрхийлж, амиа алдагсдын ар гэрийнхэнд эмгэнэл илэрхийлсэн юм. Түүнчлэн дэлхийн алдартай барилгууд солонгын долоон өнгөөр гэрэлтэж хохирогчдод хүндэтгэл үзүүлжээ.

### Токиогийн захирагч огцорлоо

Японы нийслэл Токио хотын захирагч 67 настай Ёичи Масузоэ албан тушаалаа урвуулан ашиглаж, улсын төсвийг шамшигдуулсан хэргийнхээ хариуцлагыг үүрч, албан тушаалаасаа огцорлоо. Улмаар түүний өргөдлийг Токио хотын зөвлөл хүлээн авснаар энэ сарын 21-ний өдөр үүрэгт ажлаа хүлээлгэн өгөхөөр болсон юм. Түүнчлэн Хотын Ерөнхий зөвлөл болон Комэй нам өнгөрөгч лхагва гарагийн өглөө түүнд итгэл үзүүлэх асуудлаар хуралдаж, ихэнх нь эсрэг байр суурийг илэрхийлснээр Ёичи хотын даргын суудлаас огцрохоос өөр аргагүй болсон байна. Эдүгээг хүртэл хотын Ерөнхий зөвлөл захирагчдаа итгэл үзүүлэх эсэх асуудлаар хуралдаж байсан тохиолдол бараг үгүй ажээ. Тэрбээр Токио хотын захирагчаар сонгогдсоноосоо хойш хоёр жил дөрвөн сарын хугацааны дараа огцорсон юм. Ёичи Масузоэг төсвийн хөрөнгөөр гэр бүлийн аялал зохион байгуулж, урлагийн олон арван бүтээл худалдан авсан хэрэгт буруутгагдсан байдаг. Японы зарим хэвлэлд бичсэнээр 67 настай Ёичи Масузоэ 2013 онд гэр бүлийн аялалд 2000 гаруй ам.доллар, 2014 онд мөн дээрх зорилгоор 1200 ам.долларыг төсвийн хөрөнгөнөөс шамшигдуулсан байна. Мөн 2012-2013 оны хооронд 13.260 ам.долларыг урлагийн бүтээл худалдан авахад зарцуулсан байж болзошгүй гэж орон нутгийн сонинууд уламжилж байв. Японы "Санкэй" сонинд бичсэнээр Ёичи "улс төр болоод мөнгө"-ний дуулианд нэр холбогдон Токио хотын захирагчийн үүргийг гүйцэтгэх хугацаагаа дуусгалгүй суудлаасаа бууж буй хоёр дахь хүн болжээ. Хотын сонгуулийн Ерөнхий хорооноос мэдээлснээр Токио хотын захирагчийн сонгуулийн сурталчилгааг ирэх сарын 14-ний өдөр эхлүүлж, 31-ний өдөр нь санал хураалтыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа гэнэ.

...Иракийн арми лалын хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийн хяналтад буй Фаллужах хотыг чөлөөлөх дайнаа өнгөрөгч сараас эхлүүлсэн байдаг. Тэгвэл Иракийн цэргийн ажиллагаа үр дүнгээ өгч Фаллужах хотын төв хэсгийг хэт даврагчдаас бүрэн чөлөөлснөө тус улсын арми өчигдөр зарлалаа...

### Британийн улстөрч эмэгтэй буудуулж, амиа алджээ

Энэ долоо хоногт Их Британийн ард түмэн нэгэн чухал сонголтыг хийх билээ. Тус улсад энэ сарын 23-нд Европын холбоонд үлдэх эсэх асуудлаар бүх нийтийн санал асуулга зохион байгуулагдах юм. Улс, тэр дундаа Европын холбооны цаашдын ирээдүйд том өөрчлөлт оруулж мэдэх санал асуулгатай холбоотойгоор дэлхийн томоохон удирдагчид хийгээд олны танил хүмүүс байр сууриа илэрхийлсээр байгаа. Тэгвэл санал асуулгаас урьтаж нэгэн харамсалтай хэрэг гарсан. Тодруулбал, Их Британи ЕХ-нд үлдэх ёстой гэдгийг уриалж ирсэн конгрессийн эмэгтэй гишүүн гэмт этгээдэд буудуулж амиа алдсан ноцтой хэрэг гарсан юм. Цагдаагийн байгууллага хэргийн газрын ойролцоо гэмт хэрэгтнийг баривчилсан бөгөөд одоогоор сэтгэхүйд нь ямар нэг өөрчлөлт байгаа эсэхийг шалгаж байгаа юм байна. Хэрэг пүрэв гарагийн үдээс хойш 13.00 цагийн үед гарсан байна. Английн Уэст Йоркшир мужийн номын сангийн өмнө Хөдөлмөрийн намын конгрессийн гишүүн Жо Кокс гэгч эмэгтэйг үл таних нэгэн эрэгтэй буудаж, дараа нь хүйтэн мэсээр эрэмдэглэн амь насанд нь халдсан аймшигт хэрэг гарсан байна. Хэргийн дараа бүсгүй эмнэлэгт хүргэгдсэн ч, удалгүй нас баржээ. Үүнээс гадна хэргийн газарт байсан 77 настай эрэгтэй ч гэсэн шархадсан гэсэн мэдээлэл байна. Хэрэг үйлдсэн этгээд 52 настай байжээ. Кокс 41 настай хоёр ч хүүхдийн ээж байсан гэнэ. Тэрээр сүүлийн үед сошиал сүлжээгээр дамжуулан ард иргэдэд ЕХ-нд үлдэх сонголтыг хийхийг уриалж байсан байна. Одоогоор энэ удаагийн хэрэг санал асуулгатай холбоотой эсэх нь тодорхойгүй байгаа юм. Гэхдээ хэрэгтэн анхны мэдүүлэгтээ "Би Их Британийн төлөө урвагчдыг цааш нь харуулах болно" гэсэн тухай зарим эх сурвалж онцолж байна.

### Иракийн арми Фаллужах хотын төв хэсгийг чөлөөлөв

Иракийн арми лалын хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийн хяналтад буй Фаллужах хотыг чөлөөлөх дайнаа өнгөрөгч сараас эхлүүлсэн байдаг. Тэгвэл Иракийн цэргийн ажиллагаа үр дүнгээ өгч Фаллужах хотын төв хэсгийг хэт даврагчдаас бүрэн чөлөөлснөө тус улсын арми өчигдөр зарлалаа. Нийслэл Багдаад хотоос баруун тийш 50 км зайд байрлах Эль Фаллужах хот нь 2014 оны нэгдүгээр сараас хойш хоёр жил хагасын хутацаанд "Лалын улс" бүлэглэлийн хяналтад байжээ. Хотын төв хэсгийг эзэлснээр "Халифын вант улс" байгуулснаа зарлаж, өнгөрсөн хугацаанд маш өргөн газар нутгийн хяналтдаа аваад байсан Лалын улс бүлэглэлийн хувьд том цохилт болсон гэдгийг эх сурвалж онцолж буй. Гэхдээ арми Фаллужах хотын бүх газар нутгийг хараахан чөлөөлөөгүй байгаа юм. Иракийн Ерөнхий сайд Хайдер ал Абади Фаллужах хотын Засгийн газрын төв байранд Иракийн тугийг мандуулж, Фаллужах хотыг эзэлснээ зарласан ч, хойд хэсгийн ихэнх газар нутаг нь одоо ч хэт даврагч бүлэглэлийн хяналтад байгаа билээ. Тиймээс тэд дараагийн удаа хотын хойд хэсгийн газар нутаг руу халдахаар бэлтгэж байна. Мөн дараагийн удаа "Лалын улс" бүлэглэлийн хамгийн том түшиц цэг болж буй Мосул хотыг чөлөөлөх зорилт тавин бэлтгэлээ эхлүүлжээ.

ТОМИЛОЛТ

# МАЛЧДЫН ЗАХИАЛГА ХЭРЭГЖИХЭД БЭЛЭН



С.БУЯН

...Төрөлх нутагтаа ая тухтай, тогтмол орлоготой амьдрах нөхцөл бий болбол залуу малчдын хүрээ ч өргөжих боломжтой. Малчин түмний нийгмийн баталгаа ч сайжрах боломжтой юм.

Ард иргэдийн нийтлэг эрх ашигт нэн хамаатай ч хууль тогтоох байгууллагын сейфэнд хав дараастай хэд хэдэн хуулийн төсөл байна. УИХ дахь Монгол Ардын Намын бүлгийн гишүүд өнгөрсөн дөрвөн жилд ард иргэд, ахмад настнууд, малчин түмнийхээ захиалга, даалгавраар бодитой хуулийн төслүүд санаачлан УИХ-д өргөн мэдүүлсэн юм. Гэвч эдгээр хуулийн төсөл эрх баригч намын даргын үзэмжээр хэлэлцүүлгийн шатнаас гээгдсээр парламентын бүрэн эрхийн хугацааг дуусгаж байна. Тухайлбал, Малчдын тэтгэврийн насыг таван жилээр наашлуулах, ахмад настны тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, азай буурлуудаа "Ач санах" хуулийн төслийг онцлон дурьдаж болно.

Тойрог болон орон нутагтаа ажиллах бүрт гишүүдийн чихнээс хонх уядаг нэг зүйл бол яах аргагүй малчдын нийгмийн хамгааллын асуудал байдаг. Жилийн дөрвөн улиралд цаг наргүй хөдөлмөр эрхэлж онцгой нөхцөлд ажилладаг малчдын тэтгэврийн насыг наашлуулбал эмэгтэйчүүд 50 насандаа, эрчүүд 55 насандаа тэтгэврээ тогтоолгох эрх үүсэх юм. Байнгын хорооны босгыг давсан боловч харамсалтай нь энэ хуулийн төсөл УИХ-ын нэгдсэн хуралдааны "барааг харж чадалгүй" гацсан. Харин Монгол Ардын Намын сонгуулийн мөрийн хөтөлбөртөө малчдын тэтгэврийн насыг таван жилээр наашлуулах заалт тусгаад байна.

Хуулийн төсөл нь бэлэн, боловсруулагдаад хоёр жил болсон учраас Монгол Ардын Нам малчин түмнийхээ захиас хүсэлтийг биелүүлэх бүрэн боломжтой. Энэ хуулийн төслийг Монгол Ардын Намын бүлгийн гишүүд санаачлан боловсруулж, 2014 оны нэгдүгээр сард олон нийтэд мэдээлж, зургадугаар сард УИХ-д өргөн мэдүүлжээ.

Энэ хуулийн төсөл малчдын тэтгэврийн насыг наашлуулахаас гадна малчид нийгмийн даатгалын шимтгэлээ сар, улирал, жилээр төлж болох заалттай юм. Мөн Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжсэнээс хойшхи 20 жилийн хугацаанд төлж чадаагүй болон төлөх боломжгүй байсан шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх боломжийг малчдад олгох зохицуулалттай ажээ. Өөрөөр хэлбэл, малчдад тулгамдаж буй олон асуудлыг нэг дор шийдэх хуулийн төсөл парламентын хэлэлцүүлэгт ороход бэлэн хүлээгдэж байна.

### Залуу малчид ховордож байна

Аль ч суманд очсон малчдын залуу халаа ховордож байгаа тухай хөгшчүүл өгүүлж байна. Зарим суманд 40 насны босго хэдийнэ давсан хүмүүс залуу малчинд тооцогдох нь түгээмэл болжээ. Сүүлийн үед залуучууд хөдөө нутгаа орхиж хот суурин газар бараадах болсон нь ийнхүү малчдын залуу халааг бэлтгэх асуудлыг төрийн бодлогоор дэмжих шаардлага бий болгоод байна. Амьдрал ахуйгаа өөд татахаар унасан нутаг, угаасан усаа орхиж, шинэ орчинд аж төрөхөөр ирж байгаа нь тэдний буруу биш. Гэхдээ энэ асуудлыг зөнд нь орхиж яавч болохгүй.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр манай улс 1.452.29 малчин өрхтэй. Улсын хэмжээгээр ядуурлын түвшин 27.4 хувь байгаа бол малчдынх 34.4 хувь, малчин бус иргэдийнх 24.4 хувьтай байна. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг мал аж ахуйн салбар үйлдвэрлэж, хөдөлмөр эрхэлж буй хүн амын 30 орчим хувийг малчид эзэлдэг. Түүнчлэн нийт өрхийн 20 орчим хувь нь зөвхөн мал аж ахуйн орлогоор амьжиргаагаа залгуулдаг.

Тиймээс Монгол Ардын Нам мал аж ахуй эрхлэгчдийг дэмжиж, тэдний нийгмийн баталгааг сайжруулах зорилт, бодлогыг байнга дэвшүүлж, хэрэгжүүлж ирсэн. Төрийн бодлогын цөмд байх ёстой малчин түмнийхээ амьдрал ахуйд бодитой дэм үзүүлэх үүднээс Монгол Ардын Нам мөрийн хөтөлбөртөө малчны зээлийн хүүг бууруулах, малчдын тэтгэврийн насыг таван жилээр урагшлуулах, "Мах, сүүний анхдугаар аян" санаачлан өрнүүлэх, малын махыг экспортлох, 80 гаруй хувиар үнэ нь уруудсан мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үнэ ханшийг өсгөх, боловсруулах үйлдвэрийг нутаг оронд нь байгуулах замаар малчдын амьдралыг сайжруулах олон асуудлыг цогцоор шийдэхээр мөрийн хөтөлбөртөө тусгажээ. Төрөлх нутагтаа ая тухтай, тогтмол орлоготой амьдрах нөхцөл бий болбол залуу малчдын хүрээ ч өргөжих боломжтой. Малчин түмний нийгмийн баталгаа ч сайжрах боломжтой юм.

# ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронд

# ХУВЬЦАА ХУДАЛДАЖ АВАХ НЬ ЗӨВ, БУРУУ

Засгийн газраас “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн 1072 хувьцааны 30 хувийг иргэдээс худалдаж авах шийдвэрийг өнгөрсөн долоо хоногт гаргасан билээ. Хувьцааны урьдчилгаа болох 30 хувиа улсад зарж 300 мянган төгрөгтэй болох гэсэн иргэдийг Арилжааны банкууд энэ даваа гарагаас бүртгэж эхэлсэн юм. Энэ асуудлын хүрээнд “Онцлох хуудас” булангаа бэлтгэлээ.

## ХУВЬЦААНЫ МӨНГӨ ӨНӨӨДРӨӨС ОРЖ ЭХЭЛНЭ

**2016.06.17:** -“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааны 30 хувийг Засгийн газарт худалдах иргэд өнгөрөгч даваа гарагаас арилжааны банкуудад хүсэлтээ гаргаж эхэлсэн билээ. Өнгөрөгч баасан гарагийн мэдээллээр 650 мянган иргэн хувьцаагаа худалдах хүсэлтээ банкинд гаргасан байна. Албаныхны мэдээлж буйгаар хүсэлт гаргаснаас долоо хоногийн дараа эхний 100 мянган төгрөг дансанд нь орох учиртай. Ямартай ч өнгөрөгч даваа гарагт хүсэлт гаргасан иргэдийн мөнгө өнөөдөр дансанд нь орох ёстой юм. 300 мянган төгрөгийг долоо хоногийн зайтай 100 мянгаар нь хувааж оруулна хэмээн мэдэгдээд байгаа билээ. Иргэн та хувьцаатай эсэхээ https://net.schcd.mn/registration/ эндээс шалгаж болно. Хэрэв хувьцаатай бол худалдах хүсэлтээ арилжааны аль ч банкинд гаргаж болох юм. Хувьцаагаа худалдах хүсэлтэй иргэдэд дараах шаардлагыг тавьж буй. Тодруулбал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 322-оос доошгүй ширхэг хувьцаа эзэмшдэг, банкинд хүсэлт гаргах өдрөө 18 нас хүрсэн байх, иргэний бүртгэлийн зөрчилгүй байх, иргэний цахим үнэмлэх /үнэмлэхээ гээсэн бол ТҮЦ машины лавлагаа/, тухайн банкинд данстай, эсвэл данс нээлгэсэн байх, өөрийн биеэр ирэх гэсэн шаардлагуудыг тавьж байна.

## “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”-Н 323 ШИРХЭГ ХУВЬЦААГ НЭРЛЭСЭН ҮНЭЭР НЬ ИРГЭДЭЭС ХУДАЛДАЖ АВНА

**2016.06.09:** -Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар “Эрдэнэс Тавантолгой”-н 323 ширхэг хувьцааг нэрлэсэн үнээр нь иргэдээс худалдаж авах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Засгийн газрын шийдвэртэй холбоотойгоор Ерөнхий сайд Ч.Сайханбилэг мэдээлэл хийсэн юм. Тэрбээр “Монгол Улсын иргэдэд эзэмшүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь өөрийн эзэмшлийн хувьцаагаа худалдах хүсэлт гаргасан иргэний эзэмшиж байгаа 1072 хувьцааны 30 хувьтай тэнцэх буюу 323 ширхэг хувьцааг нэрлэсэн үнээр нь иргэдээс худалдаж авах шийдвэрийг Засгийн газрын хуралдаанаас гаргалаа. “Сайн хувьцаа” арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд цаашид иргэдийн гарт үлдэх буюу 70 хувьтай тэнцэх хувьцааг нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан худалдан авахаар төлөвлөж байна. Иргэдийн 1072 хувьцааг худалдан авах эрх зөвхөн Засгийн газарт нээлттэй. Өнгөрсөн хугацаанд Засгийн газар иргэдийн тодорхой хэсгээс “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг нь нэрлэсэн үнээр худалдан авсан. Нийт хоёр сая 858 мянган иргэн хувьцаа эзэмшсэнээс давхардсан тоогоор 278 мянган оюутанд нийт 138 тэрбум төгрөг, 2011 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр 615 мянган иргэнд нийт 4.8 тэрбум төгрөгөөр, ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй 322 мянган иргэнд 322 тэрбум төгрөгөөр давхардсан тоогоор нэг сая 216 мянга 734 иргэнд 464.8 тэрбум төгрөгөөр хувьцааг нь мөнгөжүүлсэн байна. Эдгээрээс бусад 1 сая 650 мянган иргэний хувьцаа мөнгөжөөгүй байгаа юм. Эдгээр иргэд өөрийн эзэмшлийн хувьцаагаа худалдах хүсэлт гаргавал эхний ээлжинд 323 хувьцааг нь нэрлэсэн үнээр нь худалдаж авахаар болж байна” хэмээсэн юм.

## Б.БОЛОР: “САЙН ХУВЬЦАА” ХӨТӨЛБӨР АСУУДАЛ ҮҮСГЭХГҮЙ

*/Сангийн сайд/*

**2016.06.16:** -Засгийн газрын ээлжит бус хуралдаан зургадугаар сарын 16-нд болж, “Сайн хувьцаа” арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргалаа. “Сайн хувьцаа” арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг 15 хүртэл жилийн хугацаатай, дотоодын зах зээлд үе шаттайгаар гаргаж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн энгийн хувьцааны ногдол ашиг болон тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдсанаас олох орлогоос эргэн төлөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэн холбогдох гэрээ байгуулж ажиллахыг Сангийн сайд Б.Болорт даалгалаа. “Эрдэнэс Тавантолгой” компанийн өөрийн эзэмшлийн хувьцааг худалдах хүсэлт гаргасан Монгол Улсын иргэний эзэмшиж байгаа 1072 хүртэлх энгийн хувьцаанаас эхний ээлжинд 322 хувьцааг багцаар нь 300426 төгрөгөөр зохих журмын дагуу шууд, цаашид үлдэх хувьцааг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан худалдан авахаар шийдвэрлэлээ. Засгийн газрын хуралдааны дараа Сангийн сайд Б.Болор мэдээлэл хийж, “Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар “Сайн хувьцаа” хөтөлбөрийн журмыг хэлэлцэж, тогтоолд зарим өөрчлөлт оруулахаар шийдвэрлэлээ. Хэвлэл мэдээллийн зарим хэрэгслээр “Сайн хувьцаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд улсын төсөвт дарамт учруулж, хууль зөрчиж байна гэсэн мэдээлэл цацагдсан байна. Ийм зүйл байхгүй. Мөн ирэх сараас цалин тэтгэврийн асуудал хүндэрнэ, урсгал зардлаа санхүүжүүлж чадахгүй гэсэн мэдээллүүд үндэслэлгүй болохыг мэдэгдэж байна. Цалин тэтгэвэр, урсгал зардлууд хуваарийн дагуу хийгдэж байгаа, цаашид ч асуудал гарахгүй” гэж хэллээ.



## С.ЭРДЭНЭ: 1072 ХУВЬЦААНЫ 30 ХУВИЙГ ХУДАЛДАЖ АВАХ АСУУДАЛ СОНГУУЛЬТАЙ ЯМАР Ч ХАМААГҮЙ

*/ХАХНХ-ын сайд/*

**2016.06.13:** -Тэрбээр “Монгол Улсын Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар Эрдэнийн хувь буюу 1072 ширхэг хувьцааны 30 хувийг тухайн иргэн өөрөө хүссэн тохиолдолд Засгийн газар өөрийн хөрөнгөөр худалдан авах, дараа нь хувьцааны үнэ өссөн тохиолдолд анх худалдсан үнээрээ буцаан худалдаж авч болдог байх тогтоол шийдвэрийг гаргалаа. Энэ ажлыг зохион байгуулах үүрэг Сангийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд ногдсон байгаа. Тиймээс дээрх ажлыг манай Нийгмийн халамж, үйлчилгээний Ерөнхий газар зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа орсон байна. Хувьцааныхаа 30 хувийг зарах хүсэлтэй иргэд нийслэл болон орон нутагт арилжааны банкинд өөрийн биеэр очиж, тодорхой маягт бөглөх замаар хүсэлтээ гаргаж, гарын үсгээ зурж баталгаажуулах ёстой. Үүний дагуу Нийгмийн халамж, үйлчилгээний Ерөнхий газар арилжааны банкууд болон Монголбанктай хамтран хүүхдийн мөнгө олгодог зарчмаар бүх тулгалтуудыг хийж, эргээд Монголбанкаар дамжуулан иргэдийн дансанд мөнгийг хийх маягаар асуудлыг шийдвэрлэх юм. Мөнгөн дүнгийн хувьд нэг сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй хувьцааны 30 хувь 300 мянган төгрөг байгаа. Энэ үйл ажиллагаа Засгийн газрын тогтоолыг дагаж гарсан журмын дагуу энэ долоо хоногоос улс орон даяар хэрэгжиж эхэлнэ. Иргэн өргөдлөө өгснөөс хойш долоо хоногийн дараа тухайн иргэний дансанд хувьцааны 30 хувьтай тэнцэх хэмжээний мөнгө орж эхлэх юм. Арилжааны банкинд очихдоо иргэн иргэний үнэмлэхээ авч очих, тогтсон үнэт цаасны төвлөрсөн тооцоо арилжааны төвийн гаргасан маягтыг бөглөж, өөрийн гарын үсгээ зурж өгснөөр иргэний хийх ажил болно. Цаашдаа Монголбанкаар дамжиж, нийслэлийн Халамж үйлчилгээний ерөнхий газрын холбогдох хүмүүс иргэдийн мэдээллийг нягталж тулгасны дараа эрх бүхий иргэдийн мөнгө арилжааны банкаар дамжин дансанд нь орох юм. Түүнчлэн, хувьцааны 30 хувьтай тэнцэхүйц 300 мянган төгрөг зуу, зуун мянгаар гурав хуваагдан иргэдийн дансанд орно. Мөн эхэлж хүсэлт гаргасан нь мөнгөө авч, сүүлийнх нь хувьцаагаа зарах боломжгүй үлдэнэ гэсэн асуудал байхгүй. Иргэд мөнгөө бүрэн авч дуусах хугацааг тодорхойлох боломжгүй. Энэ мөн сонгуультай ямар ч хамаагүй. Сонгууль болдогоороо болно” хэмээн мэдэгдсэн юм.

## ХУУЛЬ БУСААР ХУВЬЦАА ОЛГОСОН ЗАСГИЙН ГАЗРЫГ ШҮҮХЭД ӨГНӨ

**2016.06.15:** -Засгийн газрын шийдвэрийг зарим нэгэн нэр дэвшигчид буруутгаж, Сонгуулийн тухай хууль зөрчсөн хэмээн шүүхэд нэхэмжлэл гаргахаар болжээ. Тодруулбал, ИЗНН-аас УИХ-ын 69 дүгээр тойрогт нэр дэвшиж байгаа С.Батбаатар шүүхэд хандахад бэлэн болсон гэнэ. Энэ талаар тэрбээр “АН-аас Сонгуулийн тухай хуулийн 70.1.8-ийг зөрчсөн гэж үзэж байна. Үүнд “хишиг, хувь, хувьцаа, бэлэн мөнгө, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалтыг хориглоно” гэж заасан заалтыг АН-ынхан зөрчсөн. Сонгуулийн жил гарсаны дараа ийм зүйл амлаж хийхийг хатуу хориглодог хуулийн заалттай. Гэтэл сонгуулийн сурталчилгаа эхэлсэн энэ өдрүүдэд ийм байдлаар иргэдийн тархийг угааж, ард түмнийг туйлдуулж байгаа нь хууль бус шийдвэр юмаа. Нэг хүнд 300 мянга гэхээр нийт 900 тэрбум төгрөгийг хаанаасаа яаж олох гээд байгаа юм бэ. Төсвийн алдагдал хэдэд хүрсэн байгаа билээ. Тиймээс манай төр ийм хэмжээний ачааллыг даахгүй. Ард түмний итгэл сэтгэлзүйгээр тоглож байна. Энэ бол зүгээр сонгуулийн хоосон амлалт шоу юм. Цөөн хэдэн хүн хүртээд өнгөрнө. Тиймээс би АН-ыг шүүхэд өгч байгаа юм. Өнөөдөр өмгөөлөгчөөрөө дамжуулан гаргасан нэхэмжлэлээ шүүхэд хүргүүлнэ. Шүүх Сонгуулийн тухай хууль болон бусад хууль дүрмийн дагуу ажиллаж зөв шийдвэр гаргана гэдэгт итгэлтэй байна” гэлээ.

## “САЙН ХУВЬЦАА”-Г ҮНЭТ ЦААСНЫ МЭРГЭЖИЛТНҮҮД ЭСЭРГҮҮЦЭВ

**2016.06.14:** -Монгол Улсын Засгийн газраас “Сайн хувьцаа” хөтөлбөрийг энэ сарын 13-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн билээ. Засгийн газраас гаргасан тогтоолд Монгол Улсын насанд хүрсэн иргэн бүр “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь өөрийн эзэмшлийн 1072 хувьцаанаас 322 ширхгийг нь арилжааны банкуудаар дамжуулан худалдах боломжтой болсон. Гэвч Засгийн газрын энэхүү гэнэтийн шийдвэрийг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагууд, үнэт цаасны мэргэжилтнүүд эсэргүүцэж буйгаа мэдэгдэн, хэвлэлийн хурал хийлээ. “Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо”-ны дарга Б.Өлзийбаяр “Монгол Улсын иргэн бүрт эрх тэгш оногдох энэхүү хувьцаа брокер диллерийн компаниар дамжин, иргэдэд хүрэх ёстой. Гэвч Засгийн газар үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, бусад хууль тогтоомж, хөрөнгийн зах зээлийн тогтолцооны зарчмуудыг бүдүүлгээр зөрчсөн” хэмээн байр сууриа илэрхийллээ. Мөн “Засгийн газар энэ арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор 1.65 их наяд төгрөгийн бонд босгож эхэлсэн. Гэхдээ зөвхөн насанд хүрсэн иргэд гэж заасан нь сонгуулийн сурталчилгаа ч байж магадгүй” хэмээсэн юм.

Сэтгүүлчийн өнцөг

# ХУВЬЦААГ АМЬ ОРУУЛАХ ЁСТОЙ, ГЭХДЭЭ...

Э.ТУУЛ

Одоогоос таван жилийн өмнө буюу 2011 оноос хойш иргэн бүрт “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 ширхэг хувьцааг УИХ, Засгийн газраас олгосон. Гэтэл иргэдийн эзэмшилд байгаа энэхүү хувьцаа “үхмэл” хэвээрээ л байгаад байсан. Харин гурван сарын өмнөөс 1072 ширхэг хувьцааг гадны иргэд худалдаж авч байгаа талаар шуугиж, Урт цагааны урд байрлах Тайванийн төвийн үүдэнд “1072 хувьцаагаа хятадуудад зарья” гэсэн хүмүүс ихээр цугласан. Заримынх нь хэлснээр иргэдээр данс нээлгэсэн хуулгын баримт бөглүүлээд гэрээ хийлгээд хувьцааг нь 400 000- 1 600 000 төгрөгийн хооронд авч байна гэж байв. Үүнээс үүдэж хүмүүс тус төвийн эргэн тойронд өдөр шөнөгүй бужигнах болсон. Түүгээр ч барахгүй хувьцаа худалдаж авч буй гэх этгээдүүд байршлаа сольж, Эмээлтэд хүртэл төвхнөж байв. Улмаар 8... УНА дугаартай LAND 200 маркийн автомашинтай этгээдүүд зөвхөн хүүхэд, эмэгтэйчүүдийг суулган, олны хөлнөөс зайдуу аваачиж, хувьцааг нь худалдан авдаг гэх яриа ч дэгдээд байсан юм.

Харин тавдугаар сарын 19-нд дээрх цуурхлыг анх тараасан этгээдийг Чингэлтэй дүүргийн цагдаагийн газраас баривчилсан. Өөрийгөө Монголын залуучуудын холбооны ажилтан хэмээн танилцуулсан Д.Дашням гэгч этгээд 1072 ширхэг хувьцааг хятадууд худалдаж авч байна гэх цуурхалыг анх тарааж, олон нийтийн дунд үймээн самуун үүсгэсэн нь тогтоогдсон. Д.Дашням нь “Дархан Монгол ногоон нэгдэл” ТББ-ын тэргүүн бөгөөд одоогоор түүнийг ямар зорилгоор цуурхал тараасныг тогтоохоор Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтсийнхэн ажиллаж байгаа. Үүнээс гадна “Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаапах төв” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Э.Алтаншагай гэдэг хүн ч хувьцааг амь оруулах шаардлагатай хэмээгээд иргэдийг хувьцааны дансаа нээлгэхийг шахаж эхэлсэн. Нэг иргэн хувьцааны дансаа нээлгэхэд 5000 төгрөг төлсөн гэвэл чамгүй их мөнгө хуримтлагдсан нь мэдээжийн хэрэг. Хувьцаатай холбоотой ийм асуудлууд үүсч, иргэд ч хувьцаагаа худалдах хүсэлтэй байгаа нь харагдсан болохоор Засгийн газраас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 хувьцааны 30 хувийг худалдаж авах шийдвэрийг өнгөрсөн долоо хоногт гаргасан нь зөв шийдвэр байсан хэмээн иргэдийн дэмжлэгийг хүлээн авч эхэлсэн. Гэхдээ үүнтэй зэрэгцээд нэлээд эсэргүүцэлтэй тулгарав бололтой. Учир нь Засгийн газрын шийдвэрийн дагуу иргэд арилжааны банкуудын аль ч салбарт иргэний үнэмлэхтэйгээ очоод л өөрийн нэрийн дансандаа хувьцааны мөнгөө авах боломжтой болсон нь Үнэт цаасны арилжаа эрхлэгч байгууллагуудын хувьд хохиролтой байсан нь дамжиггүй. Учир нь тэд хувьцааны данс нээхдээ нэг иргэнээс 5000 төгрөг авч байсан нь үгүй болсонд нэлээд бухимдаж, Засгийн газар үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, бусад хууль тогтоомж, хөрөнгийн зах зээлийн тогтолцооны зарчмуудыг бүдүүлгээр зөрчсөн хэмээхийн зэрэгцээ зөвхөн насанд хүрсэн иргэд гэж заасан нь сонгуулийн сурталчилгаа ч байж магадгүй гэж хардсан юм.

Үүнтэй зэрэгцээд зарим нэр дэвшигч хүртэл Засгийн газрыг шүүхэд өгнө хэмээн мэдэгдсэн. Яг үнэндээ Сонгуулийн тухай хуулийн 70.1.8 дугаар зүйлд “...хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах”-ыг хориглох тухай заасан байгаа юм. Харин “хувьцаа худалдаж авах” гэсэн зүйл заалт, үг өгүүлбэр байхгүй. Тэгээд ч хятадуудад хувьцаагаа худалдах гэж оочер дараалал үүсгэж, өдөр шөнөгүй ээлжлэн харуулд гарч байсан хүмүүсийн хувьцааг эх орондоо үлдээх нь яагаад буруу гэж... Хүүхдийн мөнгөө сар бүр хүлээдэг айл өрхүүдэд хувьцааны мөнгө багагүй хөрөнгө оруулалт болно. Тэгэхээр нөгөө өнцгөөс нь харвал “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 ширхэг хувьцааг хятадуудад худалдалгүй, эх орондоо үлдээж байгаа нь буруу гэж үү... Хэн хэндээ хэрэгтэй л шийдвэр болсон гэж бодож байна, харин таны хувьд...

# МЭДЭЭЛЭЛ

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 2016 ОНЫ 5 ДУГААР САРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭ

### Хугацаа сунгасан тусгай зөвшөөрөл

| № | Т/З-ийн дугаар | Аймаг / хот | Сум / дүүрэг | Талбайн нэр | Тухайн суманд хамаарах талбайн хэмжээ (га) | Нийт талбайн хэмжээ (га) | Тусгай зөвшөөрөл эзэмшигч | Эзэмшигч-ийн регистр | Шийдвэр-ийн огноо | Шийдвэр дугаар | Сунгагдсан байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | XV-010354 | Завхан | Шилүүстэй | Цахир уул | 2,114.91 | 2,114.91 | Жөн Юан | 2780518 | 2016.05.11 | 343 | Татгалзсан |
| 2 | XV-012479 | Ховд | Булган | Цохоор | 796.67 | 796.67 | Жи Эс Би майнинг | 5439574 | 2016.05.11 | 342 | Сунгагдсан |
| 3 | XV-012576 | Сэлэнгэ | Түшиг | Хус мод | 29.52 | 29.52 | Хусмод | 2577895 | 2016.05.24 | 399 | Сунгагдсан |
| 4 | XV-014028 | Говь-Алтай | Есөнбулаг | Хадаасан | 152.15 | 242.24 | Анирдэлхий | 5472695 | 2016.05.05 | 328 | Сунгагдсан |
| | | | Тайшир | | 86.75 | | | | | | |
| | | | Халиун | | 3.34 | | | | | | |
| 5 | XV-014496 | Говь-Алтай | Бугат | Хүнхээлт | 1,706.65 | 3,118.24 | Венера-Орд | 5096685 | 2016.05.26 | 401 | Татгалзсан |
| | | | Тонхил | | 1,411.59 | | | | | | |

### Нөхөн олгосон тусгай зөвшөөрөл

| № | Т/З-ийн дугаар | Аймаг, хот | Сум, дүүрэг | Талбайн нэр | Талбайн хэмжээ | Эзэмшигч | Эзэмшигч-ийн регистр | Шинэ тусгай зөвшөөр-лийн дугаар | Шийдвэр-ийн огноо | Шийдвэр дугаар | Дуусах огноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MV-011086 | Сэлэнгэ | Ерөө | Элээтийн ам | 774.68 | Ричмөнх | 2628058 | 20530 | 2016.05.13 | 351 | 2036.01.10 |
| 2 | MV-012577 | Сэлэнгэ | Ерөө | Сангийн гол | 252.93 | Хунан жинлэн | 2881934 | 20546 | 2016.05.23 | 387 | 2041.05.09 |

### Барьцаалсан тусгай зөвшөөрөл

| № | Т/З-ийн дугаар | Аймаг, хот | Сум / дүүрэг | Талбайн нэр | Нийт талбайн хэмжээ (га) | Тусгай зөвшөөрөл эзэмшигч | Эзэмшигч-ийн регистр | Шинэ барьцаалагч | Шинэ барьцаа-лагчийн регистр | Шийдвэр-ийн огноо | Шийдвэр дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MV-006784 | Төв | Заамар | Баржин | 172.07 | АШБ | 2555409 | Төрийн банк | 5341469 | 2016.05.13 | 352 |

### Шинээр олгосон ашиглалтын тусгай зөвшөөрөл

| № | Т/З-ийн дугаар | Аймаг, хот | Сум, дүүрэг | Талбайн нэр | Нийт талбайн хэмжээ (га) | Тусгай зөвшөөрөл эзэмшигч | Эзэмшигч-ийн регистр | Үүссэн тусгай зөвшөөр-лийн дугаар | Шийдвэр-ийн огноо | Шийдвэр дугаар | Олгосон огноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | XV-007305 | Өмнөговь | Гурвантэс | Шанд-1 | 2,899.28 | Агммайнинг | 5176727 | 20529 | 2016.05.10 | 334 | 2016.05.12 |
| 2 | XV-007334 | Баянхонгор | Баян-Өндөр | Хул морьт | 989.90 | Хулморьт майнинг | 5353246 | 20561 | 2016.05.23 | 378 | 2016.05.26 |
| 3 | XV-007337 | Баянхонгор | Баян-Өндөр | Улаан толгой | 979.68 | Хулморьт майнинг | 5353246 | 20562 | 2016.05.23 | 377 | 2016.05.26 |
| 4 | XV-007340 | Ховд | Зэрэг | Ембүү толгой | 844.73 | Брэйвхарт ресорсиз | 2878992 | 20534 | 2016.05.02 | 319 | 2016.05.16 |
| 5 | XV-007560 | Говь-Алтай | Алтай | Тэрэгтийн нуруу | 2,000.03 | Өү Жи Си Эйч Эл | 5198429 | 20566 | 2016.05.27 | 405 | 2016.05.27 |
| 6 | XV-009447 | Өмнөговь | Гурвантэс | Тооройт уул-1 | 17,102.64 | Меншикуание | 5235839 | | 2016.05.24 | 400 | Татгалзсан |
| 7 | XV-009448 | Өмнөговь | Гурвантэс | Зүрх уул-1 | 51,783.78 | Меншикуание | 5235839 | | 2016.05.24 | 400 | Татгалзсан |
| 8 | XV-010177 | Дорноговь | Даланжаргалан | Бор толгой | 86.73 | Монзол | 2654652 | 20559 | 2016.05.23 | 375 | 2016.05.26 |
| 9 | XV-010778 | Сэлэнгэ | Орхонтуул | Цоохор морьт | 326.53 | Өгөөжбаян хангай | 5515882 | 20533 | 2016.05.13 | 353 | 2016.05.16 |
| 10 | XV-012404 | Сүхбаатар | Түвшинширээ | Жоншит | 63.20 | Монголианминералз питии | 5248809 | 20542 | 2016.05.13 | 354 | 2016.05.23 |
| 11 | XV-012886 | Хэнтий | Цэнхэрмандал | Хадагтай | 653.73 | Жирэглэхгэрэл | 5194075 | 20527 | 2016.05.02 | 318 | 2016.05.09 |
| 12 | XV-013216 | Дорнод | Баяндун | Хуурай хөндий | 46.21 | Амикаголд | 5104483 | 20522 | 2016.05.03 | 321 | 2016.05.03 |
| 13 | XV-013259 | Увс | Түргэн | Нүүрст уул-3 | 864.23 | Говь-Эрээн | 5260833 | 20524 | 2016.05.03 | 322 | 2016.05.04 |
| 14 | XV-014843 | Баянхонгор | Баян-Өндөр | Хул морьт-1 | 309.35 | Хулморьт майнинг | 5353246 | 20563 | 2016.05.23 | 380 | 2016.05.26 |
| 15 | XV-015214 | Баянхонгор | Баян-Өндөр | Хуль морьт | 494.93 | Хулморьт майнинг | 5353246 | 20564 | 2016.05.23 | 379 | 2016.05.26 |
| 16 | XV-020466 | Булган | Бүрэгхангай | Туулын зүүн дэнж | 902.44 | Ориент майнинг инвестмент | 6004296 | 20565 | 2016.05.27 | 404 | 2016.05.27 |

### Хэсэгчлэн болон бүхэлд нь буцаасан тусгай зөвшөөрөл

| № | Т/З-ийн дугаар | Аймаг, хот | Сум, дүүрэг | Талбайн нэр | Талбайн хэмжээ (га) | Нийт талбайн хэмжээ (га) | Буцаасан хэлбэр | Тусгай зөвшөөрөл эзэмшигч | Эзэмшигч-ийн регистр | Шийдвэр-ийн огноо | Шийдвэр дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MV-011666 | Төв | Баянчандмань | Цагаан даваа-3 | 21.59 | 21.59 | хэсэгчлэн | Монвольфрам | 2743744 | 2016.05.24 | 397 |
| 2 | MV-016981 | Сэлэнгэ | Баянгол | Наран | 0.23 | 0.23 | хэсэгчлэн | Хонгорын орд | 2577453 | 2016.05.02 | 316 |
| 3 | MV-019327 | Дорнод | Баянтүмэн | Хөөвөрбулаг | 28.36 | 28.36 | хэсэгчлэн | Өнт-Өнгөт | 5075912 | 2016.05.24 | 396 |
| 4 | XV-008968 | Говь-Алтай | Төгрөг | Цагдуулт уул | 1,851.30 | 2,758.30 | хэсэгчлэн | Хүннү алтай минералс | 5324998 | 2016.05.24 | 395 |
| | | | Цээл | | 907.00 | | | | | | |
| 5 | XV-009922 | Баянхонгор | Гурванбулаг | Хөшөөт | 368.05 | 368.05 | хэсэгчлэн | Гацуурт | 2054701 | 2016.05.24 | 394 |
| 6 | XV-010135 | Говь-Алтай | Төгрөг | Хүрэнгийн талбай | 334.53 | 334.53 | хэсэгчлэн | Хүннү говь алтай | 5294495 | 2016.05.24 | 398 |
| 7 | XV-010308 | Говь-Алтай | Төгрөг | Сэрээгийн өндөр | 420.95 | 420.95 | хэсэгчлэн | Хүннү алтай минералс | 5324998 | 2016.05.24 | 397 |
| 8 | XV-010398 | Говь-Алтай | Төгрөг | Ацын ам | 9.15 | 9.15 | хэсэгчлэн | Хүннү говь алтай | 5294495 | 2016.05.24 | 398 |
| 9 | XV-010429 | Говь-Алтай | Төгрөг | Хүрэн гол | 45.09 | 45.09 | хэсэгчлэн | Хүннү говь алтай | 5294495 | 2016.05.24 | 398 |
| 10 | XV-012522 | Дорнод | Баянтүмэн | Хөөвөрбулаг | 1,240.54 | 1,240.54 | хэсэгчлэн | Өнт-Өнгөт | 5075912 | 2016.05.24 | 396 |
| 11 | XV-012576 | Сэлэнгэ | Түшиг | Хус мод | 218.74 | 218.74 | хэсэгчлэн | Хусмод | 2577895 | 2016.05.02 | 316 |
| 12 | XV-013045 | Дорноговь | Алтанширээ | Энгэрийн толгод | 4,240.14 | 4,240.14 | хэсэгчлэн | Пибодивинсвэй ресорсез | 5170672 | 2016.05.20 | 374 |
| 13 | XV-013546 | Дорноговь | Сайншанд | Улаанбадрах уул | 8,227.91 | 8,227.91 | бүхэлд нь | Кожеговь | 2078449 | 2016.05.02 | 317 |
| 14 | XV-013556 | Дорноговь | Айраг | Хатгал-1 | 23.54 | 2,909.62 | бүхэлд нь /татгалзсан/ | Эм Юу Си ресорсез | 5019338 | 2016.05.11 | 344 |
| | | | Даланжаргалан | | 2,886.08 | | | | | | |
| 15 | XV-014522 | Өмнөговь | Гурвантэс | Цагаан уул | 446.42 | 3,673.82 | бүхэлд нь | Цагаан-Өвөлжөө | 5352827 | 2016.05.13 | 350 |
| | | | Ноён | | 3,227.39 | | | | | | |
| 16 | XV-017739 | Увс | Өлгий | Шаргатын уул | 452.34 | 3,547.62 | хэсэгчлэн | Дунгоулд | 5455219 | 2016.05.20 | 373 |
| | | Ховд | Дөргөн | | 3,095.28 | | | | | | |
| 17 | XV-019055 | Хэнтий | Бор-Өндөр | Хөх толгой | 403.82 | 403.82 | бүхэлд нь | Ньюмон ривер | 5056853 | 2016.05.11 | 341 |

### Цуцлагдсан, дуусгавар болсон тусгай зөвшөөрөл

| № | Т/З-ийн дугаар | Аймаг, хот | Сум, дүүрэг | Талбайн нэр | Тусгай зөвшөөрөл эзэмшигч | Эзэмшигч-ийн регистр | Үндэслэл | Шийдвэр-ийн огноо | Шийдвэр дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | MV-005585 | Дорнод | Баяндун | Хуурай хөндий | Тунамал шижир | 2573253 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.13 | 358 |
| 2 | XV-010354 | Завхан | Шилүүстэй | Цахир уул | Жөн Юан | 2780518 | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.04.15 | 0 |
| 3 | XV-011601 | Дорноговь | Даланжаргалан | Их эрээлж толгой | Эс Жи Эс Жи групп | 5618444 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.10 | 332 |
| 4 | XV-011679 | Ховд | Алтай | Хөх булаг | Брит осианс куание | 5209307 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.24 | 388 |
| 5 | XV-011745 | Хэнтий | Жаргалтхаан | Өвөлжөөний эх | Жи Эф Си | 5034396 | АМТ хуулийн 53-р зүйлд заасан үндэслэлээр | 2016.05.10 | 0 |
| 6 | XV-013474 | Говь-Алтай | Цээл | Шивээ-1 | Орчлон-Орд | 5152054 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.13 | 358 |
| 7 | XV-013493 | Баян-Өлгий | Дэлүүн | Цагаан толгой | Говь-Эрээн | 5260833 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.13 | 358 |
| 8 | XV-013496 | Сүхбаатар | Эрдэнэцагаан | Баянцогт | Сидакуангей | 5180945 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.13 | 358 |
| 9 | XV-013536 | Өмнөговь | Номгон | Хар | Хөххархираа | 5157153 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.13 | 358 |
| 10 | XV-013570 | Дорноговь | Даланжаргалан | Далангийн гашуун | Туяа-Үндрам | 2762684 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.24 | 388 |
| 11 | XV-013571 | Дорноговь | Даланжаргалан | Зүүн далан | Туяа-Үндрам | 2762684 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.24 | 388 |
| 12 | XV-014236 | Хэнтий | Баян-Адрага | Нулимс | Батшандас | 5208513 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.24 | 388 |
| | | | Биндэр | | | | | | |
| 13 | XV-017533 | Өмнөговь | Ханбогд | Баян хар уул | Шинэмонгол эрдэс | 5032415 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.10 | 332 |
| 14 | XV-017752 | Баянхонгор | Баацагаан | Хар ботго | Азиа пасифис майнинг | 6030351 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.24 | 388 |
| | | | Бөмбөгөр | | | | | | |
| 15 | XV-017806 | Ховд | Дөргөн | Од | Учралтномт констракшн | 5688604 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.10 | 332 |
| 16 | XV-017854 | Увс | Малчин | Улаантолгой | Сүмбэр эрдэнэ оргил | 5168945 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.10 | 332 |
| 17 | XV-017871 | Өмнөговь | Ноён | Барс | Сэлэнгэ Оч | 5512751 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.24 | 388 |
| 18 | XV-017878 | Ховд | Цэцэг | Дов | Клануэстайн майнинг | 5497248 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.10 | 332 |
| 19 | XV-017923 | Ховд | Дөргөн | Таван толгойт | Хаян | 2061651 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.24 | 388 |
| 20 | XV-017973 | Баян-Өлгий | Дэлүүн | Аг | Агайын | 2660954 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.10 | 332 |
| 21 | XV-020434 | Өмнөговь | Ханбогд | Баян хар уул | Шинэмонгол эрдэс | 5032415 | АМТ хуулийн 56-р зүйлийн 56.1.2 | 2016.05.10 | 332 |

### Шинээр олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл

| № | Өргөдлийн бүртгэлийн дугаар | Аймаг / хот | Сум / дүүрэг | Талбайн нэр | Тухайн суманд хамаарах талбай /га/ | Талбайн хэмжээ (га) | Эзэмшигч | Эзэмшигч-ийн регистр | Шинээр олгосон тусгай зөвшөөр-лийн дугаар | Тусгай зөвшөөрөл олгосон огноо | Шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | NE-025836 | Говь-Алтай | Бугат | Алтан | 914.91 | 914.91 | Жй Эй Кэй | 5036577 | XA-018658 | 2016.05.23 | 501 |
| 2 | NE-025869 | Завхан | Шилүүстэй | Мөнгөт-1 | 7,960.40 | 7,960.40 | Отгонбогд | 5340209 | XA-018691 | 2016.05.23 | 365 |
| 3 | NE-026082 | Баян-Өлгий | Ногооннуур | Бахлай | 2,979.52 | 2,979.52 | Бодь партнерс | 5883814 | XA-019016 | 2016.05.12 | 312 |
| 4 | NE-026114 | Дундговь | Өлзийт | Чулуут | 270.48 | 270.48 | Шаргал маргад | 5582342 | XA-019078 | 2016.05.11 | 249 |
| 5 | NE-026162 | Төв | Баян | Баян | 1,727.46 | 1,727.46 | Ланд-Оре | 5429617 | XA-019130 | 2016.05.26 | 365 |
| 6 | NE-026177 | Хэнтий | Цэнхэрмандал | Бор-Өндөр | 4,145.53 | 4,145.53 | ММНС | 5317568 | XA-019146 | 2016.05.03 | 299 |
| 7 | NE-026197 | Дархан-Уул | Хонгор | Могойт | 219.48 | 219.48 | Ноён зоргол хайрхан гэрэл мөнхжаргал | 5994365 | XA-019167 | 2016.05.03 | 315 |
| 8 | NE-026256 | Дорнод | Баяндун | Өвөлжөөт | 1,276.20 | 1,276.20 | Кеестонресурс | 3860698 | XA-019238 | 2016.05.03 | 307 |
| 9 | NE-026272 | Булган | Бүрэгхангай | Бүрэг | 1,000.20 | 1,000.20 | Күүпермен | 5636655 | XA-019254 | 2016.05.03 | 312 |
| 10 | NE-026318 | Сүхбаатар | Сүхбаатар | Зүүн | 15,972.81 | 15,972.81 | Түмэн усч | 5982715 | XA-019302 | 2016.05.09 | 299 |
| 11 | NE-026331 | Өмнөговь | Ханбогд | Баг | 14,575.13 | 14,575.13 | Херуга-Эксплорэйшн | 5513901 | XA-019315 | 2016.05.13 | 339 |
| 12 | NE-026341 | Төв | Лүн | Туул | 962.01 | 962.01 | Мөнгөн нахиа | 5951259 | XA-019325 | 2016.05.13 | 312 |
| 13 | NE-026490 | Дорнод | Баяндун | Дун-2 | 1,790.94 | 1,790.94 | Универсалнобле системс | 5792843 | XA-019486 | 2016.05.16 | 307 |
| 14 | NE-026508 | Дундговь | Өндөршил | Шилийн эрдэнэс | 10,856.64 | 10,856.64 | Билгүүн үйлс | 4000897 | XA-019507 | 2016.05.19 | 348 |
| 15 | NE-026514 | Хэнтий | Батноров | Баянхаан | 2,332.88 | 2,332.88 | Гео орон ресоурсис | 5611857 | XA-019513 | 2016.05.05 | 299 |
| 16 | NE-026522 | Булган | Бүрэгхангай | Бүрэг | 146.38 | 146.38 | Тэнгэрийн хорвоонжиг | 5110467 | XA-019521 | 2016.05.13 | 313 |
| 17 | NE-026548 | Дорнод | Чойбалсан | Баян | 3,194.96 | 3,194.96 | Холбообаян нуур | 5240484 | XA-019548 | 2016.05.03 | 307 |
| 18 | NE-026580 | Төв | Өндөрширээ | Их хайрхан | 21,056.36 | 21,056.36 | Гео хайгуул | 5962544 | XA-019580 | 2016.05.12 | 324 |
| 19 | NE-026744 | Төв | Архуст | Дэлгэр-2 | 2,593.73 | 2,593.73 | Универсалнобле эйм | 5795885 | XA-019762 | 2016.05.09 | 296 |
| 20 | NE-026785 | Дорнод | Дашбалбар | Даш-3 | 9,737.45 | 9,737.45 | Универсалнобле линк | 5795915 | XA-019803 | 2016.05.16 | 307 |
| 21 | NE-026819 | Хэнтий | Батноров | Уудам | 1,121.92 | 1,121.92 | Наймган-Орд | 2057417 | XA-019838 | 2016.05.26 | 364 |
| 22 | NE-026882 | Дорноговь | Алтанширээ | Хар уул | 1,282.14 | 1,282.14 | Шинэ оюут майнинг | 5864232 | XA-019917 | 2016.05.12 | 331 |
| 23 | NE-026913 | Дорнод | Баяндун | Баяндун | 3,624.80 | 3,624.80 | Ачлалт хүү | 5959462 | XA-019951 | 2016.05.03 | 306 |
| 24 | NE-026924 | Сүхбаатар | Сүхбаатар | Сүхбаатар | 3,019.71 | 3,019.71 | Нэгүн гэрэгэ | 5920566 | XA-019962 | 2016.05.05 | 299 |
| 25 | NE-026957 | Баян-Өлгий | Ногооннуур | Ногооннуур | 1,359.44 | 1,359.44 | Би Ти Ти Ай | 5884802 | XA-019995 | 2016.05.13 | 339 |
| 26 | NE-027027 | Булган | Баяннуур | Нуур | 4,700.64 | 4,700.64 | Универсалнобле машинери | 5793254 | XA-020070 | 2016.05.11 | 299 |
| 27 | NE-027049 | Хэнтий | Батноров | Баруун баян | 4,281.82 | 4,281.82 | Лугийн гол | 5189594 | XA-020092 | 2016.05.03 | 299 |
| 28 | NE-027131 | Дорноговь | Айраг | Модот-3 | 2,988.57 | 2,988.57 | Батбадмаараг | 6009565 | XA-020181 | 2016.05.23 | 348 |
| 29 | NE-027154 | Хэнтий | Батноров | Зүүн баян | 1,453.62 | 1,453.62 | Лугийн гол | 5189594 | XA-020204 | 2016.05.03 | 299 |
| 30 | NE-027163 | Хэнтий | Батноров | Авдрант уул | 1,846.34 | 1,846.34 | Номулан хүдэр | 3749681 | XA-020213 | 2016.05.05 | 299 |
| 31 | NE-027172 | Хэнтий | Цэнхэрмандал | Их зүүн | 455.01 | 455.01 | Авад ресурс | 6009328 | XA-020222 | 2016.05.11 | 330 |
| 32 | NE-027282 | Дорноговь | Өргөн | Өргөн | 8,382.09 | 8,382.09 | Эхлэл ургац энержи | 5353564 | XA-020347 | 2016.05.03 | 290 |
| 33 | NE-025873 | Говь-Алтай | Тайшир | Мөнгөт-2 | 15,667.97 | 16,829.43 | Отгонбогд | 5340209 | XA-018695 | 2016.05.23 | 365 |
| | | Завхан | Цагаанчулуут | | 1,161.45 | | | | | | |
| 34 | NE-026896 | Дорнод | Баян-Уул | Уулс-2 | 6,404.93 | 6,792.91 | Универсалнобле химикал | 5795486 | XA-019931 | 2016.05.09 | 296 |
| | | | Цагаан-Овоо | | 387.97 | | | | | | |
| 35 | NE-026975 | Дорноговь | Алтанширээ | Галт | 3,949.69 | 3,949.70 | Эрдэнэ дисковери | 5979021 | XA-020013 | 2016.05.26 | 368 |
| | | | Их хэт | | 0.00 | | | | | | |
| 36 | NE-026997 | Ховд | Манхан | Алаг тэх | 1,148.73 | 2,511.63 | Юнайтедстийл фрейм | 5640334 | XA-020035 | 2016.05.26 | 1173 |
| | | | Мөнххайрхан | | 1,362.90 | | | | | | |
| 37 | NE-026437 | Төв | Алтанбулаг | Хар уул | 8,633.33 | 14,053.45 | Гео хайгуул | 5962544 | XA-019433 | 2016.05.12 | 324 |
| | | | Баянхангай | | 2,525.93 | | | | | | |
| | | | Лүн | | 2,894.19 | | | | | | |

**АМГ-ын КАДАСТРЫН ХЭЛТЭС**

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## Он гарсаар 143 хүн авто замын ослоор амиа алджээ

2016 оны нэгдүгээр сарын 1-нээс зургадугаар сарын 16-ны байдлаар улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 143 хүн амь насаараа хохирчээ. Үүнээс нийслэлд 37, орон нутагт 106 хүн зам тээврийн ослын улмаас амиа алдсан байна. Мөн зам тээврийн ослын улмаас 604 хүн хүнд хөнгөн гэмтсэн бөгөөд нийслэлд 382, орон нутагт 222 байгаа аж. Тиймээс Улаанбаатар хотын Замын цагдаагийн газраас урин дулаан цаг ирж байгаатай холбогдуулан хөдөө орон нутгийн замд явахдаа тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг сайтар шалгах, гүйцэж түрүүлэх үйлдэл хийхдээ аюулгүй байдлаа сайтар хангахыг анхааруулллаа. Түүнчлэн тээврийн хэрэгслийн хурдыг замын хөдөлгөөний дүрэмд заасан дээд хязгаараас хэтрүүлэхгүй байх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх, хамгаалах бүсийг байнга хэрэглэж хэвшихийг сануулж байна.

## УНШИГЧДАД ЗОРИУЛЖ БАГЦ НОМЫН САНАЛ ГАРГАЖЭЭ

Н.БАТЗА□А

*“Зуныг номтой өнгөрүүлцгээе” аян өнгөрсөн баасан гарагт эхэллээ. Тус аяныг “Монсудар” хэвлэлийн газар, “Интерном” номын дэлгүүртэй хамтран дөрөв дэх жилдээ зохион байгуулж байна. Аяны талаар “Монсудар” хэвлэлийн газрын ажилтан Л.Энхсайханаас зарим зүйлийг тодрууллаа.*

**-“Зуныг номтой өнгөрүүлцгээе” аян эхэлсэн. Аяныхаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-“Зуныг номтой өнгөрүүлцгээе” аяныг дөрөв дэх жилдээ зохион байгуулж байна. Уламжлал болсон үйл ажиллагаа. Энэ зун манай улсад сонгууль, АСЕМ-ын 11 дэх удаагийн уулзалт болж байгаа нь нэг талаар сонирхолтой. Гэхдээ нөгөө талаар сонгуулийн сурталчилгаа, элдэв ухуулах хуудас хүмүүсийг стресст оруулж, залхааж байгаа шүү дээ. Тэгэхээр энэхүү залхмаар, уйтгартай байдлаас түр ч болтугай холдохын тулд зуны амралтаараа хүссэн номоо уншиж, оюундаа хөрөнгө оруулалт хийхийг “Зуныг номтой өнгөрүүлцгээе” аян уриалдаг юм. Өөрийн хүссэн газраа амрах зуураа сонирхолтой ном барьж суух үнэхээр сайхан. Тиймээс залуучуудаа энэ боломжийг олгохын тулд аянаа дөрөв дэх жилдээ зохион байгуулж байна.

**-Дөрөв дэх удаа зохион байгуулж байгуулж байгаа гэлээ. Энэ жилийн онцлог юу байх вэ?**

-Өмнө нь бид Соёлын төв өргөөнд нэгдсэн байдлаар номын танилцуулга, өдөрлөг хийж байлаа. Мөн үндэсний соёл, амралтын хүрээлэнд номын өдөрлөг зохион байгуулж тэмдэглэсэн. Хүмүүсийг зуны дэлгэр цагаа номтой өнгөрүүлэхэд уриалсан энэхүү үйл ажиллагаа маань энэ жил гурван үе шаттайгаар зохион байгуулагдана. Тодруулбал, шинэ номын танилцуулгууд хийгдэнэ. Эцэг, эхчүүдэд зориулсан сургалт болон ном тойрсон төрөл бүрийн сонирхолтой сэдвүүдээр хэлэлцүүлэг болно. Номын хямдралтай худалдаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Ер нь бид энэ жил хүмүүсийг ном уншуулах, зуныг номтой өнгөрүүлэх гэсэн зорилгодоо илүү ойртож, хүрч ажиллахыг зорьсон. Тэр ч утгаараа багц номыг гаргалаа. Тухайлбал, бороотой өдөр гэртээ ямар ном уншвал тохиромжтой болохыг зөвлөж, номын багц гаргасан. Мөн аяллаар явахдаа үүргэвчиндээ ямар ном байлгах ёстой, хөтөч орчуулагч нарт, залуу уншигчдад гэх мэтчилэн есөн төрлийн багц бий. Товчхон хэлэхэд энэ жилийн аяны маань онцлог гэвэл уншигчдад санал болгож буй багц юм.

**-Багцынхаа талаар тодруулахгүй юу. Ямар ном орсон бэ?**

-Нийт есөн багц бий. Тодруулбал, залуу уншигчдад, дэлхийн бэстселлер, үлгэрийн хотхонд, хөтөч орчуулагч нарт, сонсдог ном, модны сүүдэрт хайрттайгаа, бороотой өдөр гэртээ, аяллын үүргэвчинд, хээрийн гал тогоонд гэсэн багцыг аяныхаа хүрээнд гаргасан. Жишээлбэл, хээрийн гал тогоонд багцад “Мах ном”, “Гал тогооны ном”, “Бялуу хийх бяцхан хөтөч” зэрэг ном орсон. Харин залуу уншигчдад багцад “Бодит байдлын ид шид”, “Би хэн бэ?”, “Хайрлах урлаг”, “Зуун жилийн ганцаардал”, “Миний мэдэх сайн үйлс”, “Тиффаныгийн дэргэдэх өглөөний цай”, “Амьтны ферм”, “Вироника үхэхээр шийдсэн нь” гэсэн ном бий. Энэ мэтчилэн зуныг ном уншиж, хөгжилтэй өнгөрүүлэхэд туслах олон төрлийн багцууд байгаа.

**-Хүүхдийн багцад ямар ном багтсан бэ. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Хүүхдийн номын багцуудад ихэвчлэн үлгэрийн ном орсон. Монголардынүлгэр,Гриммийн үлгэр, Маршакийн үлгэр, Андерсений үлгэр, мөн хөл нүцгэн зуны өдрүүд, 365 үдэш номуудыг хүүхэд багачуудаа зориулж багцдаа оруулсан. Ер нь хүний оюунлаг амьдралын эх үндэс хүүхэд ахуй насанд л тавигдах ёстой гэдэгтэй хүн бүр санал нийлэх байх. Хүүхдийн багцад орсон 365 үдэш ном нь эцэг эхчүүдэд 365 үдшийг хүүхэдтэйгээ хамтдаа уншиж, хамтдаа мөрөөдөхөд тусална. Мөн хүүхдийнхээ оюун ухааны өсөлт хөгжилтөд анхаарахад дэм болно.

**-Номууд хямдарсан гэсэн. Хэдэн хувь хямдарсан бэ?**

-10-30 хувь хямдарсан. Зуны турш 10-30 хувийн хямдралтай үнээр номоо худалдаж авах боломжтой.

**-Бүх номууд хямдарсан уу?**

-Үгүй зөвхөн багцад орсон номууд хямдарсан. Гэхдээ багц номыг заавал багцаар нь авах шаардлагагүй. Өөрийн уншихыг хүссэн, сонирхож буй номоо салгаж авах боломжтой. Нэг ном авсан ч гэсэн тухайн номоосоо шалтгаалж 10-30 хувийн хямдралтай үнээр худалдаж авч болно.

**-Номын багц, хямдралаас гадна аяны хүрээнд ямар ажил зохион байгуулах вэ. Өөр зохион байгуулах үйл ажиллагаа бий юу?**

-Бид аяныхаа хүрээнд зургаа, долоо, наймдугаар сард үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Энэ сард аяны нээлттэй холбогдуулан Японы төдийгүй дэлхийн пост модерн уран зохиолын гол төлөөлөгч Мүраками Харүкигийн бичсэн дэлхийн бэстселлер “Өнгөгүй Тазаки Цүкүри ба түүний эргэлтийн он жилүүд”, Милланиум цувралын шинэ боть болох “Аалзны торонд орооцолдсон охин” зэрэг номын нээлт боллоо. Харин долдугаар сард бие даан англи хэл суралцагсдад зориулсан цогц хичээлийн номын багц гаргана. Мөн олон улсын бэстселлер номын зохиогчийн гарын үсэгтэй худалдаа, уншигчдад зориулсан уралдаан тэмцээнүүд, хэлэлцүүлэг зэрэг олон сонирхолтой хөтөлбөрүүдийг ирэх сард зохион байгуулахаар төлөвлөсөн.

**-Англи хэлний хичээлийн цувралыг багц номд оруулна гэлээ. Ямар номууд багтах вэ?**

-Тэр талаар одоо хэлэх боломжгүй. Тухайн үед нь хүмүүст хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэнэ.

**-Зарим номын хямдралтай худалдаанд уншигчдийн хүлээсэн номууд хямдраагүй байдаг?**

-Бидний зорилго хүмүүсийг ном уншихад уриалан дуудах юм. Түүнээс биш их ном зарахдаа гол нь биш. Зуны сайхан цаг ирсэнтэй холбогдуулан уншигчдад ийм ном уншвал зүгээр гэдгийг санал болгож байгаа юм. Ямар нэгэн ашиг олох зорилго байхгүй. Бид ном унших хүмүүсийн тоог нэмэх, тэдэнд ном уншихыг уриалахыг л зорьдог. Энэ бол ямар нэгэн номын хямдралтай худалдаа биш. Харин ном уншихад уриалсан аян юм.

PHOTO NEWS





*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

*“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Соёл урлагийн газраас “Extreme Crew Studio”-тай хамтран олон улсын бүжгийн “UB DANCE FESTIVAL-2016” тэмцээнийг хоёр дахь жилдээ буюу өчигдөр Чингисийн талбайд зохион байгууллаа. Япон, БНСУ, БНХАУ зэрэг орны авьяастанууд, бүжгийн хамтлагууд нэгэн дор цуглаарч хэд хэдэн төрлийн тэмцээнээр шилдгээ шалгаруулав. Үүний нэг нь граффити зураг буюу гудамжны урлагийн аварга шалгаруулах тэмцээн байсан юм.*

## Монголын соробанч хүүхдүүд ганзага дүүрэн эх орондоо ирлээ

Японы Цүкүба хотод энэ сарын 12-нд болсон Ибараки мужийн соробан сампингийн аварга шалгаруулах тэмцээнд “Монгол соробан” төвийн 15 сурагч, гурван багш амжилттай оролцоод эх орондоо ирлээ.

Тэмцээнд 18 дугаар сургуулийн долоон настай Ц.Цэцэнбилгүүн тус мужийн бага сургуулиудын хүүхдүүдтэй өрсөлдөн хоёрдугаар байр, 97 дугаар сургуулийн сурагч 11 настай Б.Баярбаясгалан хоёрдугаар байр, нэгдүгээр сургуулийн сурагч Ө.Хатанзаяа дунд сургуулийн сурагчдын ангилалд оролцон гуравдугаар байр эзэлжээ.

Ибараки муж нь гурван сая хүн амтай бөгөөд Цүкүба хот нь эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэнгүүд төвлөрсөн, эрдэмтдийн хот юм. Ибараки мужийн аварга шалгаруулах соробангийн тэмцээн нь Улсын аварга шалгаруулах тэмцээний дараа орох том тэмцээн бөгөөд гадаад хүүхдүүд анх удаа оролцсон нь энэ юм.

Япон багш нар монгол хүүхдүүд богино хугацаанд ийм өндөр төвшинд хүрсэнд баяр хүргэн, Японд болдог олимпиад уралдаанд, ялангуяа наймдугаар сард болдог Бүх Японы соробангийн аварга шалгаруулах тэмцээнд тогтмол оролцохыг зөвлөсөн байна. Түүнчлэн “Монгол хүүхдүүдийг цаашдаа соробангаар тууштай хичээллэх юм бол япон хүүхдүүдтэй эн зэрэгцэх бүрэн боломжтой” хэмээн үнэлжээ.

## Гадаад паспортоо нэгдсэн төвүүдэд захиалдаг болов

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газраас бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилтын хүрээнд Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд гадаад паспортын үйлчилгээг нэвтрүүллээ. Уг үйлчилгээ нь гадаад паспортын ачааллыг бууруулахаас гадна иргэдийн цаг завыг хэмнэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх олон давуу талтай ажээ. Тодруулбал, гадаад паспорт шинээр захиалах иргэдээс цээж зураг зайлшгүй шаарддаг байсан бол Дүнжингарав, Драгон, Мишээл төвөөр үйлчлүүлэх иргэдээс гадаад паспортын зураг шаардахгүй бөгөөд бүртгэлийн ажилтан тухайн иргэний зургийг бүртгэл хийх үедээ авах юм байна. Мөн бэлэн болсон гадаад паспортын буцаан олголтыг иргэн өөрийн хүсэлтээр Монгол шуудан компаниар дамжуулан гэрийн болон ажлын хаягаараа авах боломжтойгоос гадна захиалсан газраасаа заасан хугацаанд авч болно.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Ихэнх нутгаар дуу, цахилгаантай бороо орно

Өнөөдөр баруун аймгуудын нутаг, төв болон говийн аймгуудын баруун хэсгээр, 21-нд ихэнх нутгаар, 22-нд төв болон зүүн аймгуудын нутгаар, 23-нд баруун болон зүүн аймгуудын нутгаар дуу цахилгаантай бороо орно. Салхи 20,21-нд ихэнх нутгаар, 22-нд говь талын нутгаар секундэд 14-16 метр хүрч ширүүснэ. Хугацааны эхээр нутгийн хойд хэсгээр сэрүүсч Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Туул, Тэрэлж голын хөндийгөөр шөнөдөө 3-8 градус, өдөртөө 13-18 градус, говийн бүс нутгаар шөнөдөө 13-18 градус, өдөртөө 26-31 градус, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус, өдөртөө 18-23 градус дулаан байна. Тиймээс ард иргэд, малчдыг гол усны үерийн аюул болон хүчтэй аянга цахилгаанаас болгоомжлохыг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс анхааруулллаа.

## Зуслангийн автобус өглөө 06:45-22:00 цаг хүртэл үйлчилнэ

Нийслэлийн тээврийн газраас зуслангийн чиглэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг энэ сарын 11-ний өдрөөс эхлэн явуулж эхэлсэн. Энэ жил зуслан руу ЗҮ:1 “Гүнт-Жигжид-Тэнгис кино театр” чиглэлд их багтаамжийн гурван автобус 36 минутын хүлээгдлийн хугацаатайгаар, ЗҮ:2 “Гоодой-Тэнгис кино театр” чиглэлд их багтаамжийн нэг автобус 01:38 минутын хүлээгдлийн хугацаатайгаар явах юм. Мөн ЗҮ:3 “Баянбулаг Тэнгис кино театр” чиглэлд их багтаамжийн нэг автобус 02:00 цагийн хүлээгдлийн хугацаатайгаар тус тус үйлчилгээ үзүүлнэ. Мөн зуслангийн чиглэлийн ХО:1 “Санзай- Тэнгис кино театр”, ХО:2 “Шарга морьт-Дүнжингарав худалдааны төв” чиглэлүүд хуучин замналаараа иргэдэд үйлчилж байна. Түүнчлэн Зуслан руу явах автобус өглөөний 06:45 цагаас эхлэн оройн 22:00 цаг хүртэл үйлчилгээ үзүүлэх ёстой аж

## СУРТАЛЧИЛГАА

